Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 7 дугаар хавсралт

# ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 1: ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ, ХӨРӨНГӨ, НӨӨЦИЙГ ХУВААРИЛАН ЗОХИЦУУЛАХ, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, БАЙГУУЛЛАГЫН САНХҮҮГ ЭРХЛЭХ, ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛЭХ, ХЭРЭГЛЭГЧИЙН ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААР САНАЛ БОЛОВСРУУЛАХ, ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙГ ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| **Зорилт 1.1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг хангах** | | | | | | | |
| 1. | Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулах, батлуулах | - | Баримт бичгийн тоо | - | 1 | Тус газрын А/99 дүгээр тушаалаар байгуулагдсан "Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын стратеги төлөвлөгөө боловсруулах" чиг үүрэг бүхий ажлын хэсэг нь "Байгууллагын 2024-2028 оны стратеги төлөвлөгөө"-ний төслийг боловсруулж холбогдох хууль тогтоомжийн дагуу батлуулахаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. | 100 |
| 2. | Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах | - | Баримт бичгийн тоо | - | 1 | Байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг 2024 оны 01 сард албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлж, 01 дүгээр сарын 02-ны өдөр батлуулсан. | 100 |
| 3. | Салбарын бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд холбогдох ажлын хэсэг, арга хэмжээнд оролцох, зохион байгуулах | Улсын төсөв | Арга хэмжээ, ажлын хэсгийн тоо | 6 | 10 | • Цахим аймаг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цахим аймаг бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэх, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, төрийн байгууллагуудын цахим шилжилтийг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах зорилготой "Digital First - Цахимд хэвшье" аяныг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны санаачилгаар 2024 оны 03-05 дугаар сард Монгол Улсын 21 аймагт зохион байгуулж тус газар нь арга хэмжээний ерөнхий зохион байгуулагчаар ажилласан.<br>• Кибер аюулгүй байдлын халдлага, зөрчилтэй тэмцэх "нийтийн төв" УТҮГ-тай хамтран Монгол Улсын хэмжээнд Кибер аюулгүй байдлын "Цахимд зөв байя" уриатай бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • "Улаанбаатар Марафон 2024" олон улсын гүйлтийн арга хэмжээний үеэр төрийн цахим үйлчилгээний Хөдөлгөөнт ХУРДАН цэгийг Сүхбаатарын талбайд байршуулан ажиллуулж хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүргэж зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан.<br>• Цагдаагийн ерөнхий газраас зохион байгуулсан "Хүүхэд таныг хамгаалъя" арга хэмжээний үеэр төрийн цахим үйлчилгээний Хөдөлгөөнт ХУРДАН цэгийг Сүхбаатарын талбайд байршуулан ажиллуулж хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүргэж зөвлөгөө мэдээллээр ханган ажилласан.<br>• Чингэлтэй дүүргийн Ялалтын талбайд зохион байгуулагдсан "Хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээ"-ний үеэр төрийн цахим үйлчилгээний Хөдөлгөөнт ХУРДАН цэгийг байршуулан ажиллуулж хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүргэж зөвлөгөө, мэдээллээр ханган ажилласан.<br>• "YOUTH MONGOLIA" Залуучуудын хөгжлийн зөвлөлийн анхдугаар чуулганд төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийг байршуулж хүн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг хүргэж зөвлөгөө, мэдээллээр ханган ажилласан.<br>• Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яамтай тус газар хамтран Төрийн бүтээмжийн сэргэлт - Цахим эрүүл мэнд арга хэмжээг 21 аймагт салбарын бодлого, эрүүл мэндийн салбарын цахим шилжилт, цахим ур чадварын сургалтыг зохион байгуулж хамтран ажилласан.<br>• Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас Дархан-Уул, Өвөрхангай аймгийг жишиг цахим аймаг болгохтой холбогдуулан шинээр нэвтрүүлсэн цахим системийг хэрэглэгч байгууллагуудад танилцуулах, хэрэглээнд нэвтрүүлэх, зүгшрүүлэх, төрийн байгууллагын цахим үйлчилгээг иргэд олон нийтэд сурталчлах, иргэдэд цахимаар төрийн үйлчилгээг хүргэх, зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохион байгуулсан.<br>• Нээлттэй мэдээллийн нэгдсэн систем /shilen.gov.mn/-ийн сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулж мэдээлэл хариуцагч байгууллагын албан хаагчдыг хамруулсан. /нийслэл, 21 аймаг/<br>• Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан Цахим аймгаас "Ухаалаг Хот" арга хэмжээнд оролцож гадаад улсын туршлага, холбогдох сургалтыг зохион байгуулж ажилласан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Цахим хөгжил, инновац, харилцаа, холбооны сайдын 2024 оны А/34 дүгээр тушаалаар байгуулагдсан Нэгдсэн Үндэсний Байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлж буй Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулж, бүх нийтийн цахим ур чадварыг нэмэгдүүлэх (DEMOSC) төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, Нэгдсэн Үндэсний Байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Нэгдсэн Үндэсний Байгууллагын хүүхдийн сантай хамтран ажиллах үүрэг бүхий ажлын хэсгийг ахлан ажилласан.<br>• Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Кибер аюулгүй байдлын зөвлөл, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн хамтран зохион байгуулсан "Кибер тусгаар тогтнол" форумд холбогдох албан хаагчдыг хамруулж мэдлэг ур чадварыг нь дээшлүүлсэн.<br>• Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/46 дугаар тушаалаар байгуулагдсан Авлигатай тэмцэх "5Ш" ажиллагааны "Шил ажиллагаа"-ны хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар ханган, шаардлагатай мэдээ, мэдээллийг нэгтгэж, шилэн индексийн үнэлгээг зарлах үүрэг бүхий штабт тус газрын холбогдох албан тушаалтнууд орж ажиллан 224 байгууллагын нээлттэй мэдээллийн "Shilen.gov.mn" системд байршуулсан мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үнэлэн, хянан баталгаажуулж, хэвлэн нийтэлсэн.<br>• "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн төрийн байгууллагын төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтэрсэн үйлчилгээнд процессын шинжилгээ хийх, дахин загварчлах, шинээр цахим хэлбэрт шилжүүлэх үйлчилгээний судалгааг гаргах ажлыг зохион байгуулах ажлын хэсэгт холбогдох албан хаагч орж 21 аймаг дахь төрийн захиргааны 25 агентлагийн үзүүлж байгаа цахим хэлбэрт шилжүүлсэн төрийн үйлчилгээний нөхцөл байдлын шинжилгээ хийх, ашиглаж буй системүүдийн судалгааг авах, цахим үйлчилгээ, сэтгэл ханамжийн судалгаа авах, ахмадуудад зориулсан сургалт зохион байгуулах, байгууллагуудын олон шатлалт үйлчилгээний сайжруулалт хийх, хуучин үйлчилгээний систем дэх өөрчлөлт хийх, шинээр нэвтрэх үйлчилгээг судлах бодлогын даалгавар боловсруулах, сумдын үйлчилгээний ажилтнуудад ERP/DOCX-системийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | талаар сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.<br>• Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/102 дугаар тушаалаар байгуулагдсан Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia.mn)-ээр үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дахин загварчлах, үе шатыг бууруулах талаар санал, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт орж төрийн үйлчилгээний нэгдсэн систем дээр байгаа үйлчилгээг нягтлах ажлыг хийж гүйцэтгэж байна. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамнаас 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 03/786 дугаар албан бичгээр ажлын хэсгээс хийх ажлыг бүрэн гүйцэтгэхэд холбогдох арга хэмжээг авах талаар чиглэл ирүүлсэн. | |
| 4. | Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангах | - | Батлагдах журмын тоо | - | 2 | Тус газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/33 дугаар тушаалаар байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг боловсруулах, өөрчлөлт оруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн баталж, биелэлтийг хангах хүрээнд:<br>• Хөдөлмөрийн дотоод журам;<br>• Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр;<br>• Төрийн болон албаны нууцыг хамгаалах дотоод журам;<br>• Цалин хөлсний журам;<br>• Цаг бүртгэлийн журам;<br>• Зайнаас болон гэрээс нь ажиллуулах журам;<br>• Удирдлагын зөвлөлийн шуурхай хуралдааны журам.<br>Нийт 7 журмын төслийг шинээр болон шинэчлэн боловсруулж, хууль тогтоомжид нийцүүлэн баталж биелэлтийг хангаж ажиллаж байна. | 100 |
| 5. | Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль, тогтоолын төсөлд санал өгөх | Улсын төсөв | Саналын тоо | 2 | 2 | Салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хууль, тогтоолын төсөлд санал өгөх хүрээнд:<br>• Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл;<br>• Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл;<br>• Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Эрхэлж байгаа зарим ажил, чиг үүргийг хувийн хэвшил, төрийн бус байгууллагад шилжүүлэх арга хэмжээний 2024 оны төлөвлөгөөний төсөл;<br>• Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн болон төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын төсөл;<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл;<br>• Төрийн албаны зөвлөлөөс боловсруулсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын төсөл;<br>• Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Удирдлагын академи, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хамтран 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн хөгжил хамгаалал" хэлэлцүүлэгт оролцож санал өгсөн;<br>• Төрийн албаны зөвлөлд Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журмын төсөл;<br>• "Танилт, нэвтрэлтийн арга, хэрэгсэл батлах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл;<br>• "Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг шинэчлэн боловсруулах зэрэг төслүүдэд тус тус санал хүргүүлсэн. | |
| 6. | Агентлагийн даргын шуурхай хурлыг зохион байгуулах, хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тайлагнах | - | Хурлын тоо | 35 | 24 | Удирдлагын зөвлөлийн хуралдааныг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах эрх бүхий байгууллагаас ирүүлсэн тогтоол шийдвэр, чиглэлийн хүрээнд зохион байгуулж, хуралдаанаас гарсан үүрэг даалгавар, шийдвэрийн биелэлтийг хангаж, хяналт тавьж, гарсан үр дүнг тухай бүр мэдээлж ажилласан. | 100 |
| 7. | Сул орон тоог нөхөх ажлыг тухай бүр зохион байгуулах | - | Арга хэмжээний тоо | 174 | 10 | Удирдах албан тушаалтан-14, гүйцэтгэх албан тушаалтан-36, нийт-50 сул орон тоог нөхөх ажлыг тухай бүр холбогдох хууль журмын дагуу зохион байгуулсан. | 100 |
| 8. | Албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин, ур чадварыг | Улсын төсөв | Үнэлгээний тоо | 5 | 14 | Албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин, ур чадварыг үнэлэх, дүгнэх ажлыг зохион байгуулах хүрээнд:<br>• 01 дүгээр сард 87; | 100 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үнэлэх, дүгнэх ажлыг зохион байгуулах | | | | | • 02 дугаар сард 102;<br>• 03 дугаар сард 107;<br>• 04 дүгээр сард 99;<br>• 05 дугаар сард 96;<br>• 07 дугаар сард 65;<br>• 08 дугаар сард 66;<br>• 09 дүгээр сард 81;<br>• 10 дугаар сард 67;<br>• 11 дүгээр сард 90 төрийн үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин, ур чадварыг үнэлэх, дүгнэх ажлыг зохион байгуулсан.<br>2024 оны 06 дугаар сарын А/58 дугаар тушаалаар Үнэлгээний баг байгуулж нийт албан хаагчийн хагас, бүтэн жилийн мэргэшлийн түвшин, ур чадварыг үнэлэх, дүгнэх ажлыг зохион байгуулсан. | |
| 9. | Мэдээлэл, харилцаа холбооны салбарын шагналд нэр дэвшүүлсэн албан хаагчийн саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх | - | Шагналд хүргүүлсэн баримт бичгийн тоо | 25 | 5 | Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 01/200 дугаар албан бичгээр "Харилцаа холбооны тэргүүний ажилтан" тэмдгээр 1, Мэдээллийн технологийн тэргүүний ажилтан 1, "Жуух бичиг"-ээр 17, нийт 19 албан хаагчийг шагнуулахаар нэр дэвшүүлж, шагнуулсан. | 100 |
| 10. | Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөө батлах, эрсдэлийн үнэлгээ хийх | - | Үнэлгээний тоо | - | 1 | Авлигаас урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг II улиралд баталж хэрэгжилтийг ханган, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажилласан. Авлигатай тэмцэх газраас "Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан сурталчлах ажлыг тасралтгүй явуулах, олон нийтийн авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, түүнтэй тэмцэх арга барилд сургах ажлыг зохион байгуулах чиглэлээр сургалт сурталчилгаа хийх" цахим сургалтад хамрагдсан. | 100 |
| 11. | Өмч хамгаалах зөвлөлийн хурлаар холбогдох асуудлыг шийдвэрлэх | - | Хурлын тоо | - | 1 | Тус газрын 2023 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/16 дугаар тушаалаар Өмч хамгаалах зөвлөлийг байгуулсан. Тус зөвлөл нь 2024 оны 04 дүгээр сард хуралдаж Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А-1/740 дүгээр албан бичгээр ирүүлсэн шийдвэрийн дагуу Хөдөлгөөнт ХУРДАН цэгийн авто машиныг Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газраас балансаас балансt шилжүүлэн авахаар шийдвэрлэсэн. | 100 |
| 12. | Эд хөрөнгийн тооллого хийх, бүртгэл хөтлөх | - | Арга хэмжээний тоо | 2 | 2 | Тус газрын Эд хөрөнгийн тооллого хийх комиссыг хагас, бүтэн жилээр баталж үйл ажиллагааг зохион байгуулж, гарсан зөвлөмж дүгнэлтийн биелэлтийг хангаж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13. | Жендэрийн үндэсний хорооны салбар зөвлөлтэй хамтран ажиллах | Улсын төсөв | Арга хэмжээний тоо | 2 | 2 | Тус газрын А/45 дугаар тушаалаар Жендерийн дэд салбар зөвлөлийг байгуулж 2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулан дараах арга хэмжээг зохион байгуулж ажилласан.<br>• Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө (2024-2027)-г албан хаагчдад танилцуулах нөлөөллийн сургалт,<br>• Ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой судалгаа авах арга хэмжээг тус тус зохион байгуулсан. | 100 |
| 14. | Байгууллагын албан бичгийн боловсруулалт, эргэлтэд хяналт тавих | - | Албан бичгийн тоо | 310 | 250 | Байгууллагаас явуулж байгаа албан бичиг, тушаал шийдвэрийг холбогдох хууль, журмын дагуу албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар, стандарт, журамд нийцүүлэн тухай бүр албажуулан ажилласан. Тайлант хугацаанд ирсэн 487, явсан 480 албан бичгийн боловсруулалт, эргэлтэд хяналт тавьж ажилласан. | 100 |
| 15. | Баримт бичиг нягтлан шалгах, бүрдүүлэлтэд хяналт тавих | - | Гүйцэтгэлийн хувь | - | 100 | • Архивын үйл ажиллагаанд мөрдөх журам, Албан хэрэг хөтлөлтийн журам, Баримт нягтлан шалгах комиссын журмын хэрэгжилтийг хангаж 2023 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ын дагуу архивд хүлээн авсан баримтыг танилцуулан, 2024 оны “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт”-ыг хянан баталгаажуулсан.<br>• “Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.6.2 дахь заалт, “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасны дагуу Архивын ерөнхий газарт архивын сан хөмрөг үүсгэх хүсэлтээ 03 дугаар сарын 11-ний өдрийн 02/55 дугаар албан бичгээр хүргүүлсэн.<br>• Архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.8 дахь заалтын дагуу холбогдох байгууллагад архивд хадгалагдсан баримт бичгээс шаардлагатай баримтын 126 лавлагаа, хуулбар олгож ажилласан. | 100 |
| 16. | Архивын бүрдүүлэлтэд хяналт тавьж, баяжилт хийх | - | Арга хэмжээний тоо | 1 | 1 | 2023 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 39 нэр төрлийн 103 хадгаламжийн нэгж бүхий архивын баримтыг хүлээн авч, байнга болон түр хадгалах баримтын данс бүртгэлийн жагсаалтыг үйлдсэн. “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт заасны дагуу зориулалтын өрөөг тохижуулан, хэрэгжилтийг ханган ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 17. | Мэдээлэл, харилцаа холбооны салбарын ажилтны өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах | Улсын төсөв | Арга хэмжээний тоо | 1 | 1 | Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн ээлжит сонгууль, шинэ Засгийн газар байгуулагдаж байгаатай холбоотойгоор тус арга хэмжээ зохион байгуулагдаагүй бөгөөд аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс аймгийн удирдлагын шийдвэрээр орон нутагт зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Тухайлбал:<br>• Хэнтий аймгийн Юнител ХК-аас 2024 оны 11 дүгээр сарын 8, 9-ны өдрүүдэд зохион байгуулсан ICT-2024 спортын 4 төрөлт /pubg, гар бөмбөг, сагсан бөмбөг, теннис/ тэмцээний сагсан бөмбөгийн төрөлд Хэнтий аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс 1-р байр эзэлж алтан медаль хүртсэн.<br>• Архангай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс нь Шуудан холбооны газартай хамтран 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр 3 төрөлт нөхөрсөг тэмцээн зохион байгуулж тус хэлтэс нь багийн дүнгээр тэргүүн байр эзэлсэн.<br>• Баян-Өлгий аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс нь аймгийн Мобиком корпорац ХХК-тай хамтран спортын арга хэмжээ зохион байгуулсан.<br>• Сэлэнгэ, Хэнтий, Говь-Алтай, Баянхонгор, Булган аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс нь Мэдээлэл, харилцаа холбооны салбарын ажилтны өдрийг тохиолдуулан зохион байгуулагдсан спортын арга хэмжээнд амжилттай оролцсон.<br>• Дорноговь аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс нь аймгийн Мобиком корпорац ХХК-тай хамтран спортын арга хэмжээ зохион байгуулсан.<br>• Өвөрхангай аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс нь нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан.<br>• Өмнөговь аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс нь Скайтел ХХК-тай хамтран спортын арга хэмжээ зохион байгуулсан. | 100 |
| 18. | Байгууллагын үйл ажиллагааны цахим мэдээллийн сан бий болгох | Улсын төсөв | Мэдээллийн сангийн тоо | - | 1 | Байгууллагын үйл ажиллагааны цахим мэдээллийн сан бий болгох хүрээнд:<br>• Байгууллагын үндсэн чиг үүрэгтэй холбоотой зохион байгуулсан үйл ажиллагааны 1200 гаруй зураг, 18 дүрс бичлэг;<br>• Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалттай холбоотой 170 гаруй зураг, 5 дүрс бичлэг;<br>• Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийг шинээр байгуулахтай холбоотой 871 зураг, 25 дүрс бичлэгийг цахим хэлбэрээр хадгалж, мэдээллийн сан үүсгэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2023 оны баримтыг тогтоол-1, А, Б тушаал-4, нэгжийн тайлан-27, ирсэн, явуулсан албан бичиг-9, албан тушаалын тодорхойлолт-2, ашиг сонирхлын мэдүүлэг-1, нийт 43 хадгаламжийн нэгж бүхий анхан шатны архивын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлсэн. | |
| **Зорилт 1.2. Албан хаагчийн чадавхыг дээшлүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах** | | | | | | | |
| 19. | Албан хаагчийг мэргэшүүлэх сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах | Улсын төсөв, тэтгэлэгт сургалт | Албан хаагчийн тоо | 25 | 25 | • Удирдлагын академийн төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 19, мэргэшүүлэх дунд хугацааны сургалтад 9, "Удирдах арга барил" сэдэвт сургалтад 1, нийт 29 албан хаагчийг тус тус хамруулсан.<br>• "Ай Си Ти Трэйнинг" ХХК-ийн "CCNA" программ хангамж, системийн аюулгүй байдлын сургалтад 4 албан хаагчийг хамруулсан.<br>• Тус газрын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/49 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу 9 албан хаагчийг судалгааны арга зүйн чиглэлээр сургалтад хамруулсан.<br>• Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO:27001, Чанарын удирдлагын тогтолцоо ISO:9001 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд дотоод аудиторын сургалтад 10 албан хаагчийг хамруулсан.<br>• Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон Онцгой байдлын ерөнхий газраас 05 дугаар сард хамтран зохион байгуулсан "Нийтийг хамарсан үйл ажиллагаа болон бусад эрүүл мэндийн аюулын үеийн бэлэн байдлын төлөвлөгөө" үндэсний төлөвлөгөөг турших сургалтад 1 албан хаагчийг хамруулсан.<br>• Нийслэл, орон нутгийн нийт 31 албан хаагчийг 2024 оны 05 дугаар сард "Сургагч багш" бэлтгэх сургалтад хамруулсан.<br>• Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх дөрөвдүгээр шатны сургалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд орон нутаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн үйлчилгээний ахлах ажилтнуудыг "Мэдээлэл технологийн үндэсний парк" Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын "Миний кодын эхлэл ментор багш"-ийн сургалтад 19 албан хаагчийг хамруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 20. | Албан хаагчийн тогтвортой ажиллах нөхцөлийг бий болгох, нийгмийн баталгааны хөтөлбөрт хамруулах | Улсын төсөв | Албан хаагчийн тоо | 13 | 5 | • Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл 3, нэг удаагийн тэтгэмж, тусламж 112, төрийн үйлчилгээний 95 албан хаагчид 12 удаагийн ур чадварын нэмэгдэл олгох ажлыг зохион байгуулж нийгмийн баталгааны хөтөлбөрт хамруулсан.<br>• Байгууллагын хэмжээнд зохион байгуулагдах сургалтын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан.<br>• Хүний нөөцийн ил тод байдлыг хангах чиглэлээр байгууллагын цахим хуудаст сул орон тооны зар, мэдээллийг хүргэх ажлыг 20 удаа байршуулж ажилласан.<br>• 2024 оны А/53 дугаар тушаалаар албан хаагчдын гэр бүл, хүүхдэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсролын ач холбогдлыг сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах, хүүхдэд ээлтэй байгууллага, хамт олныг бий болгоход дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Эцэг эхийн зөвлөл байгуулж 8 албан хаагчийн хүүхдийг цэцэрлэгт хамруулах боломжийг бүрдүүлэн ажилласан. | 100 |
| 21. | Албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны болон бусад асуудлыг шийдвэрлэх, холбогдох арга хэмжээ авах | Улсын төсөв | Санал хүсэлтийн тоо | 206 | 105 | Албан хаагчийн хөдөлмөрийн харилцааны болон бусад асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой цалинтай болон цалингүй чөлөө 25, жирэмсэн болон амаржсаны амралт 8, хүүхэд асрах чөлөө 8, нийт 41 албан хаагчийн асуудлыг шийдвэрлэж ажилласан. | 100 |
| 22. | Ёс зүйн дэд хороог байгуулах, журмын хэрэгжилтийг ханган ажиллах | Улсын төсөв | Санал, гомдлын тоо | 2 | 1 | 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/03 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороо байгуулж 10 дугаар сарын 04-ний өдрийн А/84 дүгээр тушаалаар бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулсан. 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж дараах арга хэмжээг зохион байгуулсан.<br>• Иргэн, албан хаагчаас ирүүлсэн 5 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн. Төрийн албаны зөвлөлөөс баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын төсөлд 3 санал хүргүүлж Монгол Улсын Ёс зүйн хорооны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-д тусгуулсан.<br>• Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хорооноос 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдөр хамтран зохион байгуулсан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хүрээнд "Төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн төслийг танилцуулах сургалтад 2 гишүүнийг хамруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Нийт албан хаагчдаас авсан үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх судалгаанд нийт 116 албан хаагчийг хамруулан холбогдох арга хэмжээг авч ажилласан.<br>• Үйл ажиллагааны тайланг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд улирал бүр хүргүүлэн ажилласан.<br>• Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 4 удаа зохион байгуулсан.<br>• Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, байгууллага, хамт олны сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор "Төрийн албанд танил талаараа бус мэдлэг чадвараар өрсөлддөг тогтолцоог хэвшүүлэхийн төлөө" сэдэвт контент бэлтгэж байгууллагын албан ёсны цахим хуудсаар дамжуулан түгээсэн.<br>• Сэтгэл судлалын ухааны доктор /PhD/ Б.Баярмааг урьж 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдөр нийт албан хаагчдад "Байгууллагын сэтгэл зүй" сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан.<br>• Байгууллагын нийт 18 албан хаагчийн сэтгэл зүйн тогтвортой байдалд оношилгоо хийж ганцаарчилсан зөвлөгөө өгч мэдээллээр хангаж ажилласан.<br>• Байгууллагын 2024 оны хамгийн ёс зүйтэй 3 албан хаагчийг шалгаруулж алдаршуулах арга хэмжээг зохион байгуулсан. | |
| 23. | Байгууллагын албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах | Улсын төсөв | Албан хаагчийн тоо | 57 | 64 | "Монос Групп" ХХК эрүүл мэндийн байгууллагатай хамтран 06 дугаар сард "Эрүүл биед саруул ухаан оршино" явуулын лабораторид хелико бактери, арьс, үс хуйхны шинжилгээ, дотор эхо, амны хөндий, ясны сийрэгжилт, эрдэс тодорхойлох зэрэг үзлэг шинжилгээнд тус газрын албан хаагчдыг хамруулсан. | 100 |
| 24. | Спорт зөвлөлийг шинэчлэх, арга хэмжээ зохион байгуулах | Улсын төсөв | Арга хэмжээний тоо | 2 | 3 | Идэвхтэй амьдралын хэвшилтэй албан хаагч бэлтгэх хүрээнд тус газрын албан хаагчдын бие бялдрын хөгжлийг ахиулах арга хэмжээ авах, спортоор хичээллэх төлөвлөгөөг гаргах, спортын тэмцээн зохион байгуулах, идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх орчин бүрдүүлэх чиг үүрэг бүхий Спортын зөвлөлийн шийдвэрийн дагуу бие бялдрыг хөгжүүлэх 3 арга хэмжээг зохион байгуулж нийт албан хаагчдыг хамруулсан. | 100 |
| **Зорилт 1.3. Хууль, эрх зүйн чиглэлээр мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 25. | Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд гаргасан шийдвэртэй холбогдох эрх зүйн маргааныг холбогдох эрх бүхий байгууллагаар хянан шийдвэрлүүлэх ажиллагаанд байгууллагын эрх ашгийг хамгаалан оролцох | Улсын төсөв | Итгэмжлэгдсэн төлөөлөгч томилсон тоо | - | Тухай бүр | Хууль, шүүхийн байгууллагад тус байгууллагатай холбоотой хэрэг маргаан үүсээгүй тул хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцоогүй болно. | 100 |
| 26. | Албан хаагчдад хууль, эрх зүйн чиглэлээр мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, холбогдох хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах | Улсын төсөв | Сургалтын тоо | 3 | 5 | • Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоол, Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 98 дугаар тушаалаар Аргачлал, Загваруудыг танилцуулах сургалт 1, Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах тухай 2, тайлан боловсруулах, үнэлэх аргачлалын талаарх сургалт 1 удаа тус тус зохион байгуулсан.<br>• "Төрийн болон албаны нууцыг хамгаалах дотоод журам"-ыг танилцуулах сургалтыг 5 удаа зохион байгуулж байгууллагын нийт албан хаагчдыг хамруулсан.<br>• Албан хаагчдын боловсруулсан албан бичгийн төслийг хянах, байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлаар тухай бүр мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлсэн.<br>• "Гэрээ боловсруулах, тушаалын төсөл боловсруулах аргачлал"-ын талаарх сургалтыг 5 удаа зохион байгуулсан.<br>• Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн талаарх сургалтыг Удирдлагын академийн багш нар зохион байгуулж 19 албан хаагчийг хамруулсан. | 100 |
| 27. | Нийтийн албан тушаалтны хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийг цахимаар хүлээн авч, тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргүүлэх | - | Мэдүүлэг гаргагчийн тоо | 46 | 39 | Тус газрын 46 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2023 оны байдлаар хуулийн хугацаанд бүрэн шинэчлэн гаргуулж, "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг", "Албан тушаалтнуудын 2023 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг /хураангуй/", "Мэдүүлэг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан, хугацаа хожимдуулсан албан тушаалтны нэрсийн жагсаалт", "Хувийн ашиг сонирхлын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авсан тухай бүртгэл", 2 албан хаагчийн "Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг"-ийг шинэчлэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн. | |
| 28. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллах | - | Арга хэмжээний тоо | 3 | 1 | • Тус газар нь авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг олон нийтийг соён гэгээрүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор авлигатай тэмцэхийг уриалсан утга агуулга бүхий 4 төрлийн дүрс бичлэгийг байгууллагын албан ёсны цахим хуудаст болон 21 аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн олон нийтийн сүлжээний хаягаар дамжуулан нийт 65 удаагийн нийтлэлийг иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.<br>• Монгол Улсын Засгийн газраас "2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" 49 дүгээр тогтоолд заасан "Шил" ажиллагааны хүрээнд Нийтийн мэдээллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. дэх хэсэгт заасан мэдээлэл хариуцагч байгууллагын байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг нээлттэй мэдээллийн "Shilen.gov.mn" системд байршуулсан мэдээлэл хариуцагч 224 байгууллагын нээлттэй мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үнэлэн, хянан баталгаажуулж, хэвлэн нийтэлсэн | 100 |
| 29. | Албан тушаалтнаас захиргааны шийдвэр гаргах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах үйл ажиллагаанд оролцохын өмнө тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл тайлбар гаргах, шилэн дансны цахим системд бүртгэх | - | Мэдүүлэг гаргагчийн тоо | 10 | 10 | Албан тушаалтнаас захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тухай бүр ашиг сонирхлын зөрчилгүй болохыг илэрхийлсэн мэдэгдэл тайлбарыг гаргуулж, шилэн данс, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд 35 албан хаагчийн мэдээллийг бүртгэсэн. (Үнэлгээний хорооны ажлын хэсгийн тушаалын дугаар А/09, А/10, А/15, А/17, А/18, А/37) | 100 |
| 30. | Хүн, хуулийн этгээдээс тусгай дугаараар болон бусад хэлбэрээр ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах, холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэх, хяналт тавих | Улсын төсөв | Шийдвэрл эсэн тоо | 274 | 300 | • Тус газрын өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах 7012-2626 тусгай дугаарт байршил, цагийн хуваарьтай холбоотой 273, гомдол, хүсэлт 64, талархал 194, заавар, зөвлөгөө, мэдээлэл 173, бусад асуудлаар хандсан 191, нийт 895 хүн, хуулийн этгээдийн дуудлагыг авч, холбогдох байгууллага, газар, нэгжид асуудлыг уламжлан, зөвлөгөө, мэдээллээр хангаж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Төрийн цахим үйлчилгээ, үйлчилгээний ажилтантай холбоотой 16 гомдол ирснийг хуулийн хугацаанд холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэсэн.<br>• Тус газрын дэргэдэх Ёс зүйн дэд хороонд хуваарилагдан ирсэн нийт 5 гомдлыг хууль, журмын дагуу шийдвэрлэсэн. | |
| 31. | Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурал, Байнгын хорооны болон Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдаан, төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах | - | Тайлангийн тоо | 16 | 16 | Монгол Улсын Их Хурлын тогтоол 1, Монгол Улсын Ерөнхий сайдын захирамж 1, Монгол Улсын Засгийн газрын тогтоол 11, хуралдааны тэмдэглэл 9, нийт 22 эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангаж тайланг тухай бүр холбогдох байгууллагад хүргүүлэн ажилласан.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын орон тооны бус дэд зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан арга хэмжээний биелэлтийг 04 дүгээр сарын 08, 11 дүгээр сарын 18-ны өдөр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд тус тус хүргүүлсэн.<br>• Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 4 дүгээр зүйлийн 4.2, 4.4 дэх хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Шинэ хоршоо хөдөлгөөн өрнүүлэх тухай” 166 дугаар тогтоол, Засгийн газрын 06 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэл, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын 05 дугаар сарын 02-ны өдрийн 01/363 дугаар албан бичгийн дагуу 05 дугаар сарын 09-ний өдрийн А/46 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж Архангай, Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Говь-Сүмбэр, Дорноговь, Төв, Өмнөговь, Хөвсгөл аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэс нь 05 дугаар сарын 01-31-ний өдрүүдэд батлагдсан хуваарийн дагуу сумдад томилогдон мал аж ахуй, сүү сүүн бүтээгдэхүүн, газар тариалан, арьс шир үйлдвэрлэл, ноос үйлдвэрлэлийн чиглэлээр нийт 78 хоршоог шинээр байгуулж, 3,966 өрхийн 5,454 иргэнд сургалт зохион байгуулж, уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийг сурталчлан таниулж мэдээлэл өгч ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Монгол Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хууль баталсантай холбогдуулах авах арга хэмжээний тухай 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх ХУРДАН цэгийг нийслэлийн 6 дүүргийн 65 хороо, 201 суманд нийт 296 "ХУРДАН" цэгийг шинээр тохижуулан өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байна.<br>• Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хүрээнд тус газрын 2024 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж холбогдох хуулийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна.<br>• Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 83 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нарт даалгасан. Тус газар нь 2024 оны батлагдсан төсөвт багтаан шийдвэрлэх боломжгүй байгаа тул 2025 оны урсгал төсвийн төсөлд тусгахаар ажиллаж байна.<br>• Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 84 дүгээр тогтоолын хэрэгжилтийн хүрээнд 2024 оны 01/99 албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд мэдэгдэж зөвшөөрөл олгосны дагуу нийт 4 албан хаагчийн цалинд өөрчлөлт оруулж 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдлөг болгон ажиллаж байна.<br>• Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын хүрээнд хүний нөөцийн удирдлагын нэгдсэн системд цалингийн шатлалын нэмэгдлийг шинэчлэн оруулж 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>• Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 196 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системд нийт албан хаагчийн мэдээллийг оруулж байна.<br>• Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэлд заасан "Эрүүл мэндийн цахим шинжилтийг эрчимжүүлэх" ажлын хүрээнд орон нутгийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийт 9 аймагт ажиллаж Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 09, 10, 12, 13-ны өдрүүдэд зохион байгуулж 1,100 эмч, эмнэлгийн албан хаагчийг "Төрийн бүтээмжийн сэргэлт-Монгол улсын цахим шилжилт" сэдэвт сургалтад хамруулсан. | |
| 32. | Төрийн болон албаны нууцыг хамгаалахтай холбоотой арга хэмжээг авах, холбогдох албан хаагчдад сургалт зохион байгуулах | Улсын төсөв | Арга хэмжээний тоо | - | 2 | • Тус газрын А/06 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж Тагнуулын ерөнхий газрын 2024 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 09/1007 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналд үндэслэн А/63 дугаар тушаалаар "Төрийн болон албаны нууцыг хамгаалах дотоод журам", А/87 дугаар тушаалаар "Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалт", А/70 дугаар тушаалаар "Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт"-ыг тус тус баталж 5 албан хаагчид аюулгүй байдлын шалгалт хийлгэсэн.<br>• "Төрийн болон албаны нууцыг хамгаалах дотоод журам"-ыг танилцуулах сургалтыг 5 удаа зохион байгуулж байгууллагын нийт албан хаагчдыг хамруулсан. | 100 |
| 33. | Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмыг албан хаагчдад танилцуулах, хэрэгжилтэд хяналт тавих | Улсын төсөв | Сургалт арга хэмжээний тоо | - | 5 | • Байгууллагын нийт албан хаагчдад "Архив-албан хэрэг хөтлөлтийн журам"-ыг танилцуулах сургалт 1, "Төрийн болон албан нууцыг хамгаалах дотоод журам"-ыг танилцуулах сургалт 5, "Албан хэрэг хөтлөлт"-ийн арга зүйн зөвлөгөө 3, "Гэрээ боловсруулах, тушаалын төсөл боловсруулах аргачлал"-ын талаарх сургалтыг 5 удаа тус тус зохион байгуулсан.<br>• "Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль", "Албан хэрэг хөтлөлтийн журам", "Баримт бичгийн стандарт", Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу тушаал, төлөвлөгөө, тайлан, харилцах албан бичгийг төрөлжүүлж хадгалах талаар зөвлөгөө өгч, мэдээллээр хангаж ажилласан. | 100 |
| **Зорилт 1.4. Батлагдсан төсвийг төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах, тайлагнах** | | | | | | | |
| 34. | Төсвийн жилд хэрэгжүүлэх арга хэмжээг төсвийн хязгаарт багтаан санхүүжүүлэх, зориулалтын дагуу зарцуулах, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах | Улсын төсөв | Тайлангийн тоо | 6 | 6 | Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд шинээр хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулж, төсвийн хязгаарт багтаан санхүүжүүлж зориулалтын дагуу зарцуулан, 2024 оны 01-12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн тайланг Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Сангийн яам, Нийгмийн даатгалын ерөнхий газарт тус тус хүргүүлсэн. | 100 |
| 35. | Төсвийн шууд захирагчийн төсвийн гүйцэтгэлийн болон | Улсын төсөв | Тайлангийн тоо | 2 | 2 | Төсвийн шууд захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайланд хийсэн аудитын үйл ажиллагаанаас | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулах, дүгнэлтийг хэрэгжүүлэх | | | | | зөрчилгүй дүгнэлт авч, ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийн тайланг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд 2 удаа хүргүүлсэн. | |
| 36. | Төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг хянах, санхүүжилтийг шийдвэрлэх, бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг төлөвлөх, хэрэгжилтийг хангах, тайлагнах | Улсын төсөв | Худалдан авалтын тоо | 11 | 10 | • Тус газрын бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2024 оны А/01 дүгээр тушаалаар баталж, төлөвлөгөөний дагуу нийт 7 үнэлгээний хороо, 13 ажлын хэсгийг байгуулсан. Тайлант хугацаанд төлөвлөгөөний биелэлтийг хангаж худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж ажилласан.<br>• 2024 оны А/56 дугаар тушаалаар Төсвийн шууд захирагчийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулсан.<br>• “Худалдан авах ажиллагааг, төлөвлөх тайлагнах журам”-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газрын цахим системд холбогдох тайлан, мэдээллийг тухай бүр оруулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>• Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/140 дүгээр тушаалаар “Цахим аймаг” төслийн тоног төхөөрөмж, Хороодын цахим үйлчилгээний төхөөрөмж, Цахим орчинд хүүхэд хамгааллын төхөөрөмж худалдан авах 3 арга хэмжээг зохион байгуулах эрхийг тус газарт шилжүүлсэн. Тушаалын хэрэгжилтийг хангаж “Би Си Ти” ХХК, Сод электроникс ХХК-тай худалдах, худалдан авах гэрээ байгуулан үйл ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж баримт бичгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд 01/392, 01/390 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 37. | Тухайн жилийн төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээний төсвийн зохицуулалт болон санхүүжилтэд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулах | Улсын төсөв | Саналын тоо | 2 | 2 | Төсвийн шууд захирагчийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд шинээр хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулж, зориулалтын дагуу зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, 2024 оны төсөвт батлагдсан төсөл, арга хэмжээний төсвийн зохицуулалт болон санхүүжилтэд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд 3 удаа албан бичгээр хүргүүлсэн. Тус албан бичгийн дагуу төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан. | 100 |
| 38. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах | - | Тайлангийн тоо | 12 | 12 | Шилэн дансны цахим систем (shilendans.gov.mn)-д санхүүгийн болон хүний нөөцийн холбогдох 171 мэдээллийг байршуулж сар бүрийн 07-ны өдрийн дотор нийт 12 тайлан хүргүүлж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1.5. Байгууллагын хамтын ажиллагааны талаар бодлогын хэрэгжилтийг хангах, хэрэглэгчийн үйлчилгээтэй холбоотой асуудлаар санал боловсруулах, хүн, хуулийн этгээдийг төрийн цахим үйлчилгээний талаар мэдээллээр хангах** | | | | | | | |
| 39. | Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг байгууллагын албан ёсны цахим хуудас, олон нийтийн сүлжээний хаягаар түгээх | Улсын төсөв | Мэдээ, мэдээллийн тоо | 40 | 40 | Байгууллагын албан ёсны олон нийтийн сүлжээ (фэйсбүүк пэйж)-ээр:<br>• Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 52 фото мэдээ, 26 видео мэдээ, 12 постер, 40 контент;<br>• "ХУРДАН" цэг, киоск машины үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой 39 фото мэдээ, 21 видео мэдээ, 13 постер, 29 контент;<br>• Цахим аймаг хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Цахим аймаг бодлогын зөвлөмжийг орон нутагт хэрэгжүүлэх, иргэдийн цахим ур чадварыг дээшлүүлэх, төрийн байгууллагуудын цахим шилжилтийг эрчимжүүлэх, төр, хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулах зорилготой "Digital First - Цахимд хэвшье" аянтай холбоотой 34 мэдээ;<br>• Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалттай холбоотой 42 фото мэдээ, 17 видео мэдээ, 14 постер, 38 контент буюу нийт 377 мэдээ, мэдээллийг бэлтгэн хүн, хуулийн этгээдэд олон нийтийн сувгаар хүргэн ажилласан. | 100 |
| 40. | Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах, цаг үеийн болон шуурхай мэдээ, мэдээллийг түгээх | - | Байгууллагын тоо | - | 5 | Чингэлтэй дүүргийн 24 хороо, Хан-Уул дүүргийн 25 хороо, Багахангай дүүргийн 2 хороо, Налайх дүүргийн 8 хороо, Багануур дүүргийн 5 хороонд ХУРДАН цэгийн үйлчилгээг нэвтрүүлж, Хөдөлгөөнт ХУРДАН цэг үйл ажиллагаагаа эхэлсэн талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн MNB, ntv, dardas.mn, ubn.mn, itoim.mn, amlalt.mn, vip76.mn, zuv.mn, isee.mn, mand.mn, tug.mn, mass.mn зэрэг 12, "ХУРДАН" цэг, киоск машины үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой фото мэдээ 7, видео мэдээ 5 буюу 22 мэдээг serune.mn, bataar.mn, mnews.mn, gogo.mn, ikon.mn, see.mn, eagle tv, ETV, TV5, NTV, MNB зэрэг нийт 11, Бүх нийтийн цахим ур чадвар дээшлүүлэх сургалттай холбоотой 8 видео мэдээг TV9, MNB, Air1 TV, AB телевиз, DSB TV, Гэгээнтэн ТВ, Дорнод ТВ, Дархан ТВ зэрэг 8, нийт 31 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан. | 100 |
| 41. | Байгууллагын үйл ажиллагааны талаарх танилцуулга материал бэлтгэх, хэвлэх ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Танилцуулга материалын тоо | 1 | 2 | Байгууллагын үйл ажиллагаа, төрийн цахим үйлчилгээний талаарх танилцуулга, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны санаачилгаар "Цахимд хэвшье" арга хэмжээний танилцуулга материал, "Цахимд зөв байя" уриатай кибер аюулгүй байдлын сургалтын арга хэмжээний лого, танилцуулга /стэнд/, Монгол | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улсын газрын зураг бүхий хэлбэртэй хэвлэмэл материал зэрэг нийт 5 танилцуулга материал бэлтгэн хэвлэсэн. | |
| 42. | Аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн албан ёсны цахим хаягийн хөтлөлтөд хяналт тавих, заавар зөвлөгөө өгөх | Улсын төсөв | Заавар зөвлөгөөний тоо | 21 | 49 | Орон нутаг дахь хүн, хуулийн этгээдэд байгууллагын бодлого, үйл ажиллагаа, төрийн цахим үйлчилгээг үр дүнтэй сурталчлан таниулах зорилгоор:<br>• 21 аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн албан хаагчдад хэвлэлийн мэдээ бэлтгэх, мэдээллийг хүртээмжтэй хүргэх зөвлөгөө өгч, мэдээллээр ханган ажилласан.<br>• "Цахим орчныг үр дүнтэй ашиглах нь", "Постер, рийл хэрхэн хурдан, хялбар бэлтгэх" зааврыг цахим хэлбэрээр хүргүүлсэн.<br>• 21 аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн албан ёсны цахим хуудсаар хүргэж байгаа мэдээ, мэдээллийн үнэн зөв эсэх, хандалтын тоонд тухай бүр хяналт тавьсан. Үүний үр дүнд дагагчдын тоон үзүүлэлт 2024 оны 01 дүгээр сард 11,615 байсан бол 12 дугаар сард 30,021 буюу 258 хувиар өссөн. | 100 |
| 43. | Байгууллагын цахим хуудас, олон нийтийн цахим сүлжээний хаяг хөтлөлтийг хариуцах | Улсын төсөв | Мэдээлэл хүргэсэн тоо | 1,201,980 | 1,501,980 | Байгууллагын цахим хуудас, олон нийтийн цахим сүлжээний хаягаар төрийн цахим үйлчилгээ, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт, цахим шилжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ, гадаад болон дотоод хамтын ажиллагаа зэрэг үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг бэлтгэн 1,501,233 хүн, хуулийн этгээдэд хүргэн ажилласан. | 100 |
| **Зорилт 1.6. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх** | | | | | | | |
| 44. | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны гишүүнчлэл бүхий олон улсын болон бүс нутгийн байгууллагаас тогтмол зохион байгуулдаг хурал, зөвлөгөөн, семинар, сургалтад байгууллагын төлөөллийг хамруулах ажлыг зохион байгуулах | Улсын төсөв болон зохион байгуулагч талын зардал | Сургалтад хамрагдах албан хаагчийн тоо | 5 | 5 | • Испанийн Хаант Улсад 2024 оны 02 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Дэлхийн үүрэн холбооны конгресс 2024" арга хэмжээнд 4 албан хаагч хамрагдаж олон улсын туршлага судалсан. Сургалтын дэвшилтэд технологид тулгуурлан цахим ур чадварын сургалтын танхимын төсвийн төслийг боловсруулсан. Мөн төрийн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хиймэл оюун ухааны судалгааг боловсруулсан.<br>• Бүгд Найрамдах Хятад Ард Улсад 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 30-ны өдрүүдэд хөгжиж буй орны харилцаа холбооны салбарын дэвшилтэд технологийг таниулах зорилгоор зохион байгуулсан "Яаралтай үеийн харилцаа холбооны сүлжээ" сэдэвт 14 хоногийн семинарт 1 албан хаагч хамрагдаж тус чиглэлээр суралцсан. | 100 |
| 45. | Гадаад улсын туршлагад үндэслэн төрийн үйлчилгээ хүргэх ажилтнуудыг сургах, | Улсын төсөв болон | Сургалтад хамрагдах албан | - | 2 | • Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын Америкийн Нэгдсэн Улс дахь айлчлалын хүрээнд 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 02 дугаар сарын 03-ны өдрүүдэд Монголын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэшүүлэх, харилцааны соёлыг дээшлүүлэх чиглэлээр сургалт, холбогдох бусад арга хэмжээнд хамруулах ажилд дэмжлэг үзүүлэх | зохион байгуулагч талын зардал | хаагчийн тоо | | | мэдээллийн технологийн салбарын 8 компани Америкийн Нэгдсэн Улсын цахиурын хөндийн экосистемд нэвтэрч, үйл ажиллагаанд байгууллагыг төлөөлж 1 албан хаагч оролцсон.<br>• Бүгд Найрамдах Казахстан Улсын Алматы болон Астана хотод төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэг байгуулах, "Дижитал Алматы 2024" форумд оролцох зорилгоор 2024 оны 02 дугаар сард 2 албан хаагч хамрагдсан.<br>• Бүгд Найрамдах Япон Улсын Токио хотод "Дэлхийн банк", "Токиогийн сургалт хөгжлийн төв"-ийн хамтран зохион байгуулсан "Кибер аюулгүй байдал" сэдэвт сургалтад 2 албан хаагч 07 дугаар сард хамрагдсан. Тус сургалтын туршлагад үндэслэн кибер аюулгүй байдлын "Цахимд зөв байя" уриатай цахим ур чадварын сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулж 24,280 хүн, хуулийн этгээдийг хамруулсан.<br>• Бүгд Найрамдах Узбекистан Улсын Ташкент хотод Байгаль орчин, аялал жуулчлалын яамны дэргэдэх Био аюулгүй байдлыг хангах үндэсний хороо, Олон улсын шинжлэх ухаан технологийн төвийн хамтран зохион байгуулсан "Нийтийг хамарсан үйл ажиллагаа болон бусад эрүүл мэндийн аюулын үеийн хэвлэл мэдээлэл" сэдэвт сургалт, семинарт 1 албан хаагчийг 03 дугаар сард хамруулсан. | |
| 46. | Монгол Улсын гишүүнчлэл бүхий олон улсын байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хүрээнд байгууллагын албан хаагчдыг магистр, докторын зэрэг олгох хөтөлбөрт хамруулах эхний шатны сонгон шалгаруулалтад санал хүргүүлэх | Улсын төсөв | Хүргүүлсэн саналын тоо | 1 | 2 | • Ази Номхон далайн Цахилгаан холбооны байгууллага болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний мэдээлэл технологийн салбарыг дэмжих агентлаг хамтарсан "APT-NIPA Training Program 2024" төслийн хүрээнд 2024 оны 05 дугаар сард Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотод зохион байгуулагдах "Мэдээлэл, харилцаа холбооны мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр 2024" сэдэвт сургалт, семинарт байгууллагаас 1 албан хаагчийг хамруулах саналыг Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.<br>• Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Элчин сайдын яамнаас зохион байгуулдаг "ICCR" тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд (Бакалавр, Магистр, Доктор)-ын сургалтын хөтөлбөрийг байгууллагын албан хаагчдад танилцуулж 1 албан хаагчийн мэдээллийг холбогдох байгууллагад цахимаар хүргүүлсэн. | 100 |
| 47. | Салбарын үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсад ирсэн гадаадын төлөөлөгчийг | Улсын төсөв болох зохион | Арга хэмжээний тоо | 3 | 2 | • Бүгд Найрамдах Казакстан Улсын Цахим хөгжил, инновац, сансрын аж үйлдвэрийн Тэргүүн дэд сайд, Бүгд Найрамдах Казакстан Улсын Хууль зүйн дотоод хэргийн Дэд сайд тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авах, холбогдох хурал, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хүлээн авах, арга хэмжээнд оролцох, дэмжлэг үзүүлэн ажиллах | байгууллагч талын зардал | | | | уулзалтыг Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран зохион байгуулж ажилласан. Тус уулзалтын хүрээнд талууд хамтран ажиллах хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, Төрийн цахим үйлчилгээний "Төв шуудан" дахь ХУРДАН цэгийн үйл ажиллагаатай танилцуулсан.<br>• Бүгд Найрамдах Солонгос Улсын "Сунгуг" их сургууль, "Глобал хүний нөөцийн боловсрол хөгжлийн төв"-ийн удирдлагуудтай 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдөр байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах, БНСУ-аас туршлага судлах, мэдээллийн технологийн "ХУРДАН" клубийн хүүхдүүдийг мэдээлэл технологийн чиглэлээр БНСУ-д сургах, дадлагажуулах талаар уулзалт зохион байгуулж албан хаагчдыг үе шаттайгаар сургалтад хамруулахаар шийдвэрлэсэн. | |
| 48. | Байгууллагын хэмжээнд гадаад, дотоод арга хэмжээтэй холбоотой уулзалт, хурал, семинарыг зохион байгуулах, хамтын ажиллагааг өргөжүүлэх, дэмжлэг үзүүлэх | Улсын төсөв | Арга хэмжээний тоо | - | 4 | • Дархан-Уул аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэст мэдээллийн технологийн сайн дурын ажилтан ажиллуулах тухай "Койка" Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран ажиллах талаар санал хүргүүлсэн.<br>• Төрийн цахим үйлчилгээний Ухаалаг төв, хөдөлгөөнт ХУРДАН цэг, сургалтын төв байгуулах төсөл боловсруулж Казакстаны элчин сайдын яаманд хүргүүлсэн.<br>• Тус газрын 2024 оны 01/89 дугаартай Цахим шилжилтийг эрчимжүүлэх хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Дотоодын аюулгүй байдлын яамны Цахим засаглалын үзэсгэлэнгийн танхимтай танилцах, төрийн цахим үйлчилгээний талаар туршлага судлах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх ажилд дэмжлэг үзүүлэх тухай албан бичгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.<br>• Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан "Гига" санаачилга, Боловсрол шинжлэх ухааны яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хамтран ерөнхий боловсролын сургуульд түшиглэсэн "Олон нийтийн мэдээллийн ажилтан" (ОНЦМА) бэлтгэх төслийн хүрээнд 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 28-ны өдрүүдэд Дархан-Уул, Орхон, Хэнтий, Дорнод, Дорноговь аймгийн ерөнхий боловсролын мэдээлэл зүйн 56 багшид цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулсан. Мөн Нэгдсэн үндэсний байгууллага, Хүүхдийн сан, Хөгжлийн сантай хамтран | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хөдөлгөөнт ХУРДАН цэг, цахим ур чадварын танхимыг тохижуулах чиглэлээр хамтран ажиллаж байна. | |
| 49. | Байгууллагын үйл ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах, хамтран ажиллах | - | Санамж бичгийн тоо | - | 1 | • Хүн, хуулийн этгээдэд төрөөс үзүүлж буй үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийж, төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Жижиг, дунд үйлдвэрийн газар, Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв УТҮГ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.<br>• Бүгд Найрамдах Казакстан Улсын "Үндэсний мэдээллийн технологи" ХК-тай мэдээлэл харилцаа, холбооны технологийн салбарт хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.<br>• Бүгд Найрамдах Казакстан Улсын "Үндэсний мэдээллийн технологи" ХК-тай мэдээлэл харилцаа, холбооны технологийн салбарт хамтран ажиллах санамж бичиг байгуулсан.<br>• Төрийн банк ХК-ийн киоск төхөөрөмжөөр дамжуулж төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. | 100 |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 2: ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭТЭЙ ХОЛБООТОЙ СИСТЕМ НЭВТРҮҮЛЭХ, ЗОХИЦУУЛАЛТ ХИЙХ, НЭГТГЭХ, ХЭВИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ҮЙЛЧИЛГЭЭГ ОНОВЧЛОХ, ЦАХИМЖУУЛАХ, СУДАЛГАА ХИЙХ, АЛБАН ХААГЧИЙГ САЛБАРЫН ЧИГЛЭЛЭЭР СУРГАХ, МЭРГЭШҮҮЛЭХ, БҮХ НИЙТИЙН ЦАХИМ УР ЧАДВАРЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ** | | | | | | | |
| **Зорилт 2.1. Төрийн цахим үйлчилгээтэй холбоотой системийг нэвтрүүлэх, зохицуулалт хийх, нэгтгэх, хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах, үйлчилгээг оновчлох, цахимжуулах, судалгаа хийх** | | | | | | | |
| 50. | Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр төр, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллаж төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд үйлчилгээг холбох, нэгтгэх ажлыг зохион байгуулах | Улсын төсөв | Байгууллагын тоо | 20 | 20 | • Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр "Гео инженер сурвей" ХХК-ийн хөгжүүлсэн киоск төхөөрөмжид лавлагаа, тодорхойлолтын үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажилласан;<br>• "Эм Ай Си Жи" ХХК-иар Төрийн цахим үйлчилгээний хүртээмж, сэтгэл ханамжийг тодорхойлох, цахим үйлчилгээг сайжруулах судалгааг хийх чиглэлээр хамтран ажилласан;<br>• Орхон аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 04/95 дугаартай албан бичгээр ирүүлсэн Улсын байцаагчийн ажлын байрны дүгнэлт гаргуулах хүсэлтийг хүлээн авч төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлсэн;<br>• Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-ийг ашиглаж, бүртгэл хийхэд гарч буй системийн алдааг засах тухай "Ард Кредит" банк бус санхүүгийн байгууллага ХК-ийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Цахим хэлбэрт шилжүүлэх боломжгүй үйлчилгээний талаар И-Монгол академи Улсын төсөвт үйлдвэрийн газарт ирүүлсэн саналыг үндэслэн мэдээлэл хариуцагч 15 байгууллагын 58 үйлчилгээний шалтгаан нөхцөлийг тодруулах зорилгоор мэдээлэл хариуцагч байгууллагуудтай уулзалт зохион байгуулж, 9 байгууллагын 34 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх боломжтой, 9 байгууллагын 24 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх боломжгүй болохыг уулзалтын явцад тодорхойлж, тухайн байгууллагуудаас албан бичгээр санал авч баталгаажуулж, нийт 56 байгууллагатай уулзалт зохион байгуулж салбарын зохицуулалт хийж ажилласан;<br>• Төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэг болон киоск төхөөрөмжийг виртуал оператор суурилуулж хөгжүүлэх зорилгоор техникийн нөхцөл боломжийг судалж, хөгжүүлэгч байгууллагуудтай үе шаттай уулзалт зохион байгуулан ажиллаж байна;<br>• Сангийн яамнаас төрийн үйлчилгээний төлбөрийг шуурхай төлөх "Qrcode" системийг нэвтрүүлж байгаатай холбогдуулан тус газрын төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгт ашиглагдаж буй төлбөрийн VX820 пин пад төхөөрөмжид холбогдох системийн шинэчлэлтийн тохиргоо хийлгэхээр Сангийн яам болон бусад холбогдох байгууллагатай хамтран ажиллаж байна.<br>• Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт орж төрийн үйлчилгээний нэгдсэн системд байршуулах төрийн цахим үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхойлох санал өгч, холбогдох ажлыг гүйцэтгэж байна.<br>Нийт: 22 байгууллага | |
| 51. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн хөгжүүлэлтийн явцад хяналт тавих, ХУРДАН цэгийн техник тоног төхөөрөмж, программ хангамж, сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах | Улсын төсөв | Цэгийн тоо | 144 | 156 | • Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдөр баталсан "Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийг хөгжүүлэх, алдаа доголдлыг засаж, сайжруулах ажлын төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн алдаа доголдлыг илрүүлэх, үр дүнг нэгтгэх тайлан, Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг хангах 5 төрлийн TO-BE загварын процесс зураг, гэмтэл, саатлын журмыг боловсруулж 2024 оны 08 дугаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сарын 16-ны өдрийн 01/275 дугаартай бичгээр Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн;<br>• Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн гэмтэл, саатал, алдаа, доголдол болон төрийн үйлчилгээтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх арга зүйн туслалцаа үзүүлэх, хариуцсан албан тушаалтан, дараагийн шатны байгууллага, нэгжид хүргүүлэх зорилгоор "Цахим форум"-ыг нийслэл, орон нутаг, хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрын үйлчилгээний ажилтнууд болон "И-Монгол академи" улсын төсөвт үйлдвэрийн газрын холбогдох албан тушаалтнуудыг хамруулан тогтмол зохион байгуулж ажилласан;<br>• Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийг ашиглан 43 төрийн байгууллагын 451 төрлийн үйлчилгээг нийслэлийн 101 цэг, 1 хөдөлгөөнт, орон нутгийн 282 цэг, 2 хөдөлгөөнт цэг, хилийн чанад дахь дипломат төлөөлөгчийн газрын 31 улсын 47 цэг нийт 432 цэгийн техник тоног төхөөрөмж, программ хангамж, сүлжээний хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангаж ажилласан;<br>• Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн хөгжүүлэлтийн хүрээнд "И-Монгол академи" УТҮГ-тай 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр уулзалт зохион байгуулж, Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийг сайжруулах болон алдаа, доголдлын талаар санал хүргүүлэн ажилласан. | |
| 52. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (киоск)-ийн хөгжүүлэлтийн явцад хяналт тавих, хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангах | Улсын төсөв | Киоскийн тоо | - | 20 | Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024 оны 03/884, 03/1105 дугаартай албан бичгийг үндэслэн тус газрын 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/68 дугаар тушаалаар Киоск машины байршуулалт, үйлдлийн системд хяналт, шалгалт хийх чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Тус ажлын хэсэг нь нийслэлд 127, орон нутагт 84, (тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан 22 киоск машин), хилийн боомтод 4, нийт 237 киоск машиныг байршуулан 250 киоск машинд хяналт хийж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан. Киоск төхөөрөмжид нийт 105 үйлчилгээ нэвтрэхээс идэвхтэй 86 үйлчилгээ, идэвхгүй 16 үйлчилгээг нэвтрүүлсэн;<br>Тээврийн хэрэгслийн гэрчилгээ солих, цахим тоон гарын үсэг олгох (last.kiosk.gov.mn)-ийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, системийн тохиргоо хийж, гарсан гэмтэл, саатлыг тухай бүр Үндэсний дата төв улсын төсөвт үйлдвэрийн газартай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтран шийдвэрлэж хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан. Нийт: 237 киоск нэвтрүүлсэн. | |
| 53. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, киоск), цахим лавлагааны систем, албан бичиг солилцооны систем, тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгох систем, нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний систем, и-Монгол, и-бизнес платформ, нийтийн өргөдөл гомдлын систем, төлбөрийн систем, huduu.gov.mn гэх мэт системийн хөгжүүлэлт, сайжруулалтын талаар санал боловсруулах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах | - | Зөвлөгөө, мэдээллийн тоо | 2101 | 2500 | Нийслэл, орон нутаг, хилийн боомт, хилийн чанадын дипломат төлөөлөгчийн газарт байрлах төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгийн үйлчилгээний ажилтнуудад 3,048 удаагийн зөвлөгөө, мэдээллийг хүргэж, тухай бүр алдаа, доголдлыг шуурхай шийдвэрлэж ажилласан байна.<br>Үүнд:<br>• 2023 онд төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д 1,710;<br>• 2024 онд төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д 1,283;<br>• Цахим лавлагааны систем (lavlagaa.e-mongolia.mn)-д 25;<br>• Төлбөрийн систем (tulbur.gov.mn)-д 20;<br>• huduu.gov.mn-д 10.<br>Орон нутагт шилжин суурьших шилжилт хөдөлгөөнийг дэмжих төрийн бодлогыг хэрэгжүүлэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад нэгдсэн мэдээлэл өгөх зорилго бүхий систем (huduu.mn)-д 2, нээлттэй мэдээллийн үнэлгээний систем (shilen.gov.mn)-д зэрэг системийг сайжруулах, хөгжүүлэх тухай 2, төрийн байгууллагын нэгдсэн цахим хуудас (gov.mn)-т 8, төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д 43, нийт 55 саналыг боловсруулж Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд тус тус хүргүүлсэн. | 100 |
| 54. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, киоск), цахим лавлагааны систем, төлбөрийн систем, huduu.gov.mn системийн үйл ажиллагааны талаар гарын авлага боловсруулах, сургалт зохион байгуулах | Улсын төсөв | Боловсруулсан гарын авлагын тоо | 4 | 4 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор), операторын системд ашиглаж буй тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг шалгах диаграмм, цахим лавлагааны систем, төлбөрийн систем, тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгохтой холбоотой заавар бүхий 5 гарын авлагыг боловсруулж, төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д байршуулан 150 үйлчилгээний ажилтныг сургалтад хамруулсан. | 100 |
| 55. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д дэд админ, операторын админ, операторын эрх нээх, цуцлах, хяналт тавих | - | Нээх, цуцлах эрхийн тоо | 275,<br>32 | 375<br>82 | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д 210 хэрэглэгчийн эрх нээж, 57 эрх цуцалсан нь хүний нөөцийн урсгал тогтвортой байгааг илэрхийлж байна. | 100 |
| 56. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)- | - | Байгууллагын тоо, | 51<br>467 | 5<br>180 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад тусгагдсан 785 үйлчилгээнээс Төрийн цахим | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | д нэвтрүүлэх үйлчилгээг эрэмбэлэх, санал боловсруулах, үе шаттайгаар нэмэгдүүлэх | | үйлчилгээний тоо | | | үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ээр 43 байгууллагын 451 үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа ба цахим хэлбэрт шилжүүлэх шаардлагатай 24 байгууллагын 210 үйлчилгээ, жагсаалтаас хасах 16 байгууллагын 124 үйлчилгээний жагсаалтыг эцэслэн тус тогтоолд өөрчлөлт оруулах саналыг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. | |
| 57. | Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХУР)-д холбогдох үйлчилгээ, байгууллагын тоог нэмэгдүүлэх | Улсын төсөв | Үйлчилгээний тоо, байгууллагын тоо | - | 50<br>30 | • Цахим хөгжил, харилцаа холбооны яамны чиглэлийн дагуу Мэдээлэл солилцооны систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээг тус газарт шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд 05 дугаар сарын 28-ны өдөр Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн холбогдох албан хаагчидтай хамтран бэлтгэл ажлыг хангаж ажилласан болович Засгийн газрын тогтоолоор тус газарт эрх үүргийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлээгүй байна. Тус газраас дээрх системийн гэрээ байгуулах эрхийг хүлээн авах бэлтгэл ажлыг бүрэн хангасан.<br>• Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ХУР, ДАН-ын гэрээг шилжүүлэхэд шаардагдах бэлтгэл ажлыг хангахаар холбогдох албан тушаалтнууд 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийг хүртэл гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд 30 байгууллагатай хамтран ажиллаж, зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | 100 |
| 58. | Танилт, нэвтрэлтийн дэмжих систем (ДАН)-д холбогдох байгууллагын тоог нэмэгдүүлэх | Улсын төсөв | Байгууллагын тоо | - | 100 | • Цахим хөгжил, харилцаа холбооны яамны чиглэлийн дагуу Танилт, нэвтрэлтийн дэмжих систем (ДАН)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээг тус газарт шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах хүрээнд 05 дугаар сарын 28-ны өдөр тус газрын холбогдох албан хаагчид бэлтгэл ажлыг хангаж ажилласан болович Засгийн газрын тогтоолоор тус газарт эрх үүргийг шилжүүлэх асуудлыг шийдвэрлээгүй байна. Тус газраас дээрх системийн гэрээ байгуулах эрхийг хүлээн авах бэлтгэл ажлыг бүрэн хангасан.<br>• Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас ХУР, ДАН-ын гэрээг шилжүүлэхэд шаардагдах бэлтгэл ажлыг хангахаар холбогдох албан тушаалтнууд 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл танилт нэвтрэлтийн дэмжих системийн ашиглалт, системд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбогдох нөхцөл шаардлагын талаар 100 байгууллагад зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. | |
| 59. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгээр дамжуулан тоон гарын үсэг олгох | Улсын төсөв | Тоон гарын үсэг олгох тоо | - | 20,000 | • Нийслэлийн хэмжээнд төрийн цахим үйлчилгээний 19 ХУРДАН цэг, хөдөлгөөнт 1 цэгээр дамжуулан нийт 11,310 иргэнд тоон гарын үсэг олгосон.<br>• Орон нутгийн хэмжээнд 21 аймаг дахь төрийн цахим үйлчилгээний 103 ХУРДАН цэгээр дамжуулан 13,099 иргэнд тоон гарын үсэг олгосон.<br>Нийт 22,409 тоон гарын үсэг олгосон. | 100 |
| 60. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгт хяналтын систем нэвтрүүлэх | Улсын төсөв | Системийн тоо | - | 1 | Нийслэлийн 22, орон нутагт 47 төрийн цахим үйлчилгээний "ХУРДАН" цэгт хяналтын камер нэвтрүүлж хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан. | 100 |
| **Зорилт 2.2. Албан хаагчийг салбарын чиглэлээр сургах, мэргэшүүлэх, бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх, төрийн байгууллагаас нэвтрүүлсэн системийн талаарх сургалт зохион байгуулах, үр дүнг тайлагнах** | | | | | | | |
| 61. | Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг батлах | - | Хөтөлбөрийн тоо | 5 | 5 | Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг батлах хүрээнд:<br>• "Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр" 12 сэдэв;<br>• Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудад "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтын хөтөлбөр;<br>• Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад зориулсан "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтын хөтөлбөр;<br>• Хэнтий аймаг, Чингис хот, Цэнхэрмандал, Жаргалтхаан, Мөрөн сумын төрийн албан хаагч, иргэд, ахлах ангийн сурагчдад "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, хуваарь;<br>• Аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга, холбогдох албан хаагчдыг салбарын чиглэлээр чадавхжуулах, сургагч багшаар бэлтгэх сургалтын хөтөлбөр;<br>• Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх кибер аюулгүй байдлын "Цахимд зөв байя" гуравдугаар шатны сургалтын хөтөлбөрийг тус тус боловсруулж баталсан.<br>• Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх дөрөвдүгээр шатны сургалтын хөтөлбөрийг баталсан.<br>Нийт 7 хөтөлбөр баталсан. | 100 |
| 62. | Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах | Улсын төсөв | Хамрагдах хүний тоо | 21,610 | 25,000 | • Тус газрын 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 01/323-01/343 дугаартай албан бичгээр 21 аймгийн засаг дарга нартай хамтран ажиллах саналыг хүргүүлж, Төрөөс үзүүлж байгаа | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цахим үйлчилгээтэй холбоотой асуудлаар хүн хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, төрийн цахим үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах хоёрдугаар шатны сургалтыг 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл 21 аймагт үе шаттайгаар зохион байгуулж 589 байгууллагын 21,805 төрийн албан хаагчийг хамруулсан.<br>• Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газар, Газрын алба, Биеийн тамир спортын хороо, Статистикийн хороо, Худалдан авах ажиллагааны алба, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвийн нийт төрийн албан хаагчдад 2024 оны 01 дүгээр сарын 10,11-ний өдөр "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж 235 албан хаагчийг хамруулсан.<br>• Ражив Гандийн нэрэмжит үйлдвэрлэл, урлалын политехник коллежийн багш нарт 2024 оны 01 дүгээр сарын 10,11-ны өдрүүдэд "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж 200 оюутан суралцагчдыг хамруулсан.<br>• Батлан хамгаалах яамны харьяа Аж үйлдвэрийн нэгдлийн 20 албан хаагчид 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.<br>• Сүхбаатар дүүргийн 1-20 дугаар хорооны 580 иргэнд 2024 оны 01 дүгээр сарын 24,25,26-ны өдрүүдэд "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.<br>• Зэвсэгт хүчний 334 дүгээр ангийн 80 албан хаагчид 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.<br>• Өмнөговь аймгийн 14 сумын нийт 58 байгууллагын 973 иргэн, төрийн албан хаагчийг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтад хамруулсан.<br>• Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн 150 албан хаагч, цэргийн албан хаагчийг 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдөр "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтад харуулсан.<br>• Онцгой байдлын Ерөнхий газрын 119 дүгээр ангийн Шуурхай удирдлагын газрын 30 албан хаагчид 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдөр "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны 30 албан хаагчид 2024 оны 02 дугаар сарын 25-ны өдөр "Цахим хөгжлийг дэмжих" багц хуулийн танилцуулга сургалт зохион байгуулсан.<br>• Сүхбаатар дүүргийн Ерөнхий боловсролын 1, 31, 45, 6, 11, 2, 4, 3, 16, 159, 35, Эрдмийн хөтөч цогцолбор сургууль, 71-р сургуулиудад 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдрүүдэд сургалт зохион байгуулж 3,249 багш, ажилтан, ахлах ангийн сурагчдыг хамруулсан.<br>• Сүхбаатар дүүргийн Ражив Гандийн үйлдвэрлэл, урлалын политехник коллежийн 250 оюутан, ахлах ангийн сурагчдад 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдөр "Орчин үеийн дэвшилтэт технологи", "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.<br>• Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 23, 24, 112, 5, 50, 17, 49, 39, 57, 61, Насан туршийн боловсролын төв, 72, 37, 117, 149, Бадмаараг сургуулийн нийт 1,615 багш, ажилтан, ахлах ангийн сурагчдад 2024 оны 03 дугаар сарын 20-ний өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрүүдэд "Орчин үеийн дэвшилтэт технологи", "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.<br>• Хэнтий аймаг, Чингис хот, Жаргалт хаан, Цэнхэрмандал, Мөрөн сумын 947 иргэн, төрийн албан хаагч, ахлах ангийн сурагчдад 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 2024 оны 03 дугаар сарын 30-ны өдрүүдэд "Орчин үеийн дэвшилтэт технологи", "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.<br>• Чингэлтэй дүүргийн 22-р хорооны 50 иргэнд 2024 оны 04 дүгээр сарын 04-ны өдөр "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалт буюу Тоон гарын үсэг ба түүний хэрэглээ ач холбогдол, Иргэд төрийн албан хаагчдад хэрэгцээт цахим хуудаснууд, Мэдээллийн аюулгүй байдал гэсэн сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан.<br>• Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газар, 25 хорооны нийт 120 төрийн албан хаагчид 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр"Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан.<br>• "Цахимд хэвшье" digital first-D1 арга хэмжээний хүрээнд 04 дүгээр сарын 29-ний адар Төв аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 230 сурагч, төрийн албан хаагчдад | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Тасралтгүй суралцах" сэдвээр өдөр сургалт зохион байгуулсан.<br>• Сүхбаатар дүүргийн Шинэ үе сургуулийн 3 дугаар ангийн 170 сурагчдад "Ухаалаг утасны зохистой хэрэглээ" сэдвийн хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр сургалт зохион байгуулсан.<br>• Багш хөгжлийн ордонд Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудын 100 нийгмийн ажилтан, сэтгэл судлаач нарт "Цахим орчин дахь үе тэнгийн дээрэлхэл" сэдвийн хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр сургалтыг зохион байгуулсан.<br>• "Дулааны 3 дугаар цахилгаан станц"-ын 110 ажилтан, албан хаагчдад "Цахим ур чадвар" дээшлүүлэх сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан.<br>• Кибер аюулгүй байдлын "Цахимд зөв байя" гуравдугаар шатны сургалтын хүрээнд тус газрын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 01/356 дугаартай албан бичгээр 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн Засаг дарга нартай хамтран ажиллах саналыг хүргүүлж, сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрөөс 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулан ажилласан. "Бүх нийтийн цахим ур чадвар"-ыг дээшлүүлэх гуравдугаар шатны сургалтын хүрээнд нийт 928 байгууллагын төрийн албан хаагч, ажилт, төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийн ажилтан, ерөнхий боловсролын сургууль, мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв, их, дээд сургуульд суралцагч, багш, ажилтан, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг 24,276 иргэнийг хамруулсан.<br>• Нийслэлийн хэмжээнд 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрөөс 11 дүгээр сарын 08-ны өдрүүдийн хооронд Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтэс, Татварын хэлтэс, Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлэг, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр халамж, үйлчилгээний хэлтэс, Засаг даргын Тамгын газар, Чингэлтэй дүүргийн Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар, Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар, Монгол Улсын боловсролын их сургуулийн харьяа Дүрслэх урлаг, технологийн сургууль, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Хөгжлийн бэрхшээлтэй хүний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөгжлийн ерөнхий газар зэрэг нийт 13 байгууллагын 397 албан хаагчийг хамруулсан.<br>• Орон нутагт зохион байгуулсан сургалтын хүрээнд:<br>✓ Архангай аймгийн 28 байгууллагын 1000;<br>✓ Баян-өлгий аймгийн 26 байгууллагын 945;<br>✓ Баянхонгор аймгийн 20 сумын 48 байгууллагын 985;<br>✓ Булган аймгийн 40 байгууллагын 1017;<br>✓ Говь-алтай аймгийн 27 байгууллагын 650;<br>✓ Говьсүмбэр аймгийн 24 байгууллагын 1064;<br>✓ Дархан-уул аймгийн 7 байгууллагын 1191;<br>✓ Дорноговь аймгийн 14 сумын 81 байгууллагын 1015;<br>✓ Дорнод аймгийн 7 сумын 31 байгууллагын 1124;<br>✓ Дундговь аймгийн 57 байгууллагын 2005;<br>✓ Завхан аймгийн 40 байгууллагын 729;<br>✓ Орхон аймгийн 2 сумын 45 байгууллагын 1243;<br>✓ Өвөрхангай аймгийн 19 сумын 22 байгууллагын 545;<br>✓ Өмнөговь аймгийн 5 сумын 71 байгууллагын 1984;<br>✓ Сүхбаатар аймгийн 110 байгууллагын 1142;<br>✓ Сэлэнгэ аймгийн 17 сумын 36 байгууллагын 2010;<br>✓ Төв аймгийн 27 сумын 195 байгууллагын 1382;<br>✓ Увс аймгийн 27 байгууллагын 783;<br>✓ Ховд аймгийн 365;<br>✓ Хөвсгөл аймгийн 1252;<br>✓ Хэнтий аймгийн 40 байгууллагын 1451 иргэнийг тус тус хамруулсан байна.<br>• Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан "Гига" санаачилга, Боловсрол шинжлэх ухааны яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам хамтран ерөнхий боловсролын сургуульд түшиглэсэн "Олон нийтийн мэдээллийн ажилтан" (ОНЦМА) бэлтгэх төслийн хүрээнд 2024 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 28-ны өдрүүдэд Дархан-Уул, Орхон, Хэнтий, Дорнод, Дорноговь аймгийн ерөнхий боловсролын мэдээлэл зүйн 56 багшид цахим ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулсан.<br>Нийт: 55,726 албан хаагч, иргэдэд сургалт зохион байгуулсан. | |
| 63. | Албан хаагчийг салбарын чиглэлээр сургах, мэргэшүүлэх сургалт зохион байгуулах | Улсын төсөв | Албан хаагчийн тоо | 2,016 | 2,100 | • Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /оператор/-ийн анхан болон ахисан шатны сургалтад нийслэлд шинээр томилогдсон 4, Монгол шуудан" ХК-ийн 3, "Цахилгаан холбоо" ХК-ийн 63, Орхон аймгийн хэлтэст шинээр томилогдсон 2, Хөвсгөл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | аймгийн 24 сумын 24, Баянзүрх дүүргийн 1 дүгээр хорооны 2, Чингэлтэй дүүргийн 24 хорооны 24, Хөх хот дахь консулын газрын 1, Австрали улсад суугаа элчин сайдын яамны 2, Америкийн нэгдсэн улс дахь Сан-Франциско, Чикаго, Нью Йорк, Вашингтон хот дахь салбарын 4 үйлчилгээний ажилтныг тус тус хамруулсан;<br>• Бүгд найрамдах Беларусь улсын элчин сайдын яамны төрийн үйлчилгээ үзүүлэх үйлчилгээний ажилтан, Багахангай дүүрэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн 10 ажилтан, Хан-Уул дүүргийн 25 хорооны 42 зохион байгуулагч, Баянгол дүүргийн хороодын 50 зохион байгуулагч, "Монголын цахилгаан холбоо" ХК, Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн 3 үйлчилгээний ажилтан, Орон нутаг дахь хэлтсийн 292 албан хаагч, "Монгол шуудан" ХК-ийн цэгээр үйлчилгээ үзүүлэх 8 үйлчилгээний ажилтан, Чингэлтэй, Хан-Уул, Багахангай, Налайх, Багануур, Баянзүрх дүүргийн хороодын 65 зохион байгуулагч, нийгмийн ажилтан, тус газрын 20 албан хаагчийг Кибер аюулгүй байдлын "Цахимд зөв байя" гуравдугаар шатны сургалтыг 2024 оны 10 дугаар сараас эхлэн чадавхжуулах, дадлагажуулах сургалтад хамруулсан.<br>• Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд арга хэмжээний сургалтыг 2024 оны 05 дугаар сард зохион байгуулж нийт 2000 гаруй эрүүл мэндийн салбарын албан хаагчийг хамруулсан;<br>• Орон нутаг дахь хэлтсийн 21 дарга, холбогдох албан хаагчдад 2024 оны 09 дүгээр сард салбарын хууль тогтоомжийн талаарх танилцуулга, сургалтыг зохион байгуулсан. | |
| 64. | Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх контентыг хөгжүүлэх, түгээх | Улсын төсөв | Контентын тоо | - | 50 | • Байгууллагын албан ёсны цахим хаягт бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хүрээнд Сүхбаатар дүүргийн ерөнхий боловсролын 2, 4 дүгээр сургуулийн багш, ажилтан, ахлах ангийн сурагч, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам зэрэг төрийн байгууллагын албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын 25 контент;<br>• Боловсролын яам, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран "Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан" бэлтгэх туршилтын төслийн хүрээнд "Lumi" нээлттэй цахим сургалтын системд 8 контент;<br>• Кибер аюулгүй байдлын "Цахим зөв байя" гуравдугаар шатны сургалтын хүрээнд "Кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байдал, кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам, байгууллагын мэдээллийн аюулгүй байдал, танилт, нэвтрэлт, нууцлал, хиймэл оюун ухааны эерэг болон сөрөг нөлөө, хувийн мэдээллээ зүй зохистой хамгаалах, цахим ул мөрөө хянах, хамгаалах, цахим залилангаас урьдчилан сэргийлэх, эцэг эхийн хяналтын программ, цахим орчин дахь донтолт сэтгэл зүйн нөлөөлөл зэрэг 10 контент;<br>• Кибер аюулгүй байдлын "Цахим зөв байя" гуравдугаар шатны сургалтыг хүн, хуулийн этгээдэд сурталчлан таниулах зорилгоор 27 контент бүтээж түгээсэн. | |
| 65. | Гадаад улсын туршлагад үндэслэн төрийн үйлчилгээг хүргэх албан хаагчийг сургах, мэргэшүүлэх, үйлчилгээний соёлыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах | Улсын төсөв | Албан хаагчийн тоо | 106 | 100 | • Бүгд найрамдах Казакстан улсын "ЦОН" Төрийн цахим үйлчилгээний цэгийн үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн системийг судалж, Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (Оператор)-д нэвтрүүлж, 150 үйлчилгээний ажилтнуудад тухай бүр сургалт зохион байгуулан ажилласан;<br>• Цахим хөгжил, харилцаа холбооны яам, ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран зохион байгуулсан Кибер аюулгүй байдлын сургалтад 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр холбогдох 25 албан хаагчийг хамруулсан;<br>• 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр MITRE байгууллагаас зохион байгуулсан Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх сургалтад холбогдох албан хаагчдыг хамруулсан;<br>• Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон MITRE байгууллага хамтран зохион байгуулсан "Using the NIST CSF Profile & Leading Practices" сургалтад холбогдох 2 албан хаагчийг хамруулсан. | 100 |
| 66. | Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх сургагч багш бэлтгэх | Улсын төсөв | Сургагч багшийн тоо | 30 | 30 | • Тус газрын нийслэл, орон нутгийн нийт 31 албан хаагчийг 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 24-ны өдрүүдэд "Сургагч багш" бэлтгэх сургалтад хамруулсан.<br>• Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх дөрөвдүгээр шатны сургалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 28, 29-ний өдрүүдэд орон нутаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн үйлчилгээний ахлах ажилтнуудыг "Мэдээлэл технологийн үндэсний парк" ТӨАТҮГ-ын "Миний кодын эхлэл ментор багш"-ийн сургалтад 19 албан хаагчийг хамруулсан. Нийт 76 албан хаагч. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 67. | Салбарын хууль тогтоомжийн талаарх танилцуулга, сургалт зохион байгуулах | Улсын төсөв | Сургалтын тоо | 30 | 30 | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны бодлого үйл ажиллагаа, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 109 хуулийн нэмэлт өөрчлөлт, Монгол Улсын Засгийн газрын урт хугацааны бодлого, Төрийн бүтээмжийн сэргэлт зэрэг сэдвийн хүрээнд нийслэл, орон нутгийн иргэд, төрийн албан хаагч, мэргэжлийн боловсролын сургууль, ерөнхий боловсролын сургуулийн оюутан сурагчид, цэргийн албан хаагчдад нийт 84 удаагийн сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| 68. | Кибер аюулгүй байдлын талаар мэдлэг олгох, сургалт зохион байгуулах | Улсын төсөв | Сургалтын тоо | 30 | 30 | Байгууллагын мэдээллийн аюулгүй байдал, Кибер аюулгүй байдал сэдвийн хүрээнд нийслэл, орон нутгийн иргэд, төрийн албан хаагч, мэргэжлийн боловсролын сургууль, ерөнхий боловсролын сургуулийн оюутан сурагчид, цэргийн албан хаагчдад нийт 437 удаагийн сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| 69. | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын дэвшилтэт технологийн талаар мэдлэг олгох, сургалт зохион байгуулах | Улсын төсөв | Сургалтын тоо | 30 | 30 | Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын дэвшилтэт технологийн талаар мэдлэг олгох “Орчин үеийн дэвшилтэт техник технологи”, “Хиймэл оюун ухааны эерэг болон сөрөг нөлөө” сэдвийн хүрээнд нийслэл, орон нутгийн иргэд, төрийн албан хаагч, мэргэжлийн боловсролын сургууль, ерөнхий боловсролын сургуулийн оюутан сурагчид, цэргийн албан хаагчдад нийт 250 удаагийн сургалт зохион байгуулсан. | 100 |
| 70. | Төрийн байгууллагаас нэвтрүүлсэн системийн талаарх сургалт зохион байгуулах | Улсын төсөв | Сургалтын тоо | 30 | 60 | E-kids, D-parliament, petition.parliament.mn, E-bussines, Sudalgaa.gov.mn, Shilen.gov.mn, lavlagaa.e-mongolia.mn, huduu.gov.mn, opendata.gov.mn, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, tulbur.gov.mn зэрэг Төрийн байгууллагаас нэвтрүүлсэн системийн талаар нийслэл, орон нутгийн иргэд, төрийн албан хаагч, мэргэжлийн боловсролын сургууль, ерөнхий боловсролын сургуулийн оюутан сурагчид, цэргийн албан хаагчдад нийт 93 удаагийн сургалтыг зохион байгуулсан. | 100 |
| 71. | Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах | Улсын төсөв | Байгууллагын тоо | 38 | 40 | Бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах ажлын хүрээнд Сүхбаатар дүүргийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний 4/39 дугаартай хамтран ажиллах албан бичиг, Зэвсэгт хүчний 334 дүгээр ангийн 2024 оны 01 дүгээр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сарын 30-ний 32 дугаартай хамтран ажиллах албан бичиг, Ражив Гандийн нэрэмжит үйлдвэрлэл урлалын политехник коллеж, Батлан хамгаалах яамны харьяа Аж үйлдвэрийн нэгдэл, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Сүхбаатар дүүргийн 1-20 дугаар хороо, Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн 2024 оны 01 дүгээр сарын 31-ний 72 дугаартай хамтран ажиллах албан бичиг, Онцгой байдлын ерөнхий газрын 2024 оны 02 дугаар сарын 07-ны 45/11 дугаартай хамтран ажиллах албан бичиг, Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газар, тус дүүргийн 24 хороо, Сүхбаатар дүүргийн Шинэ үе сургуулийн 175 дугаар албан бичиг, Хан-уул дүүргийн Засаг даргын тамгын газрын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 03/716 дугаартай албан бичгийн хүрээнд 25 хороо, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 03/955 дугаартай албан бичиг, Дулааны 3 дугаар цахилгаан станцын 2024 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 1/958 дугаартай албан бичиг, Монгол улсын хүний эрхийн үндэсний комиссын тамгын газрын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн ТГ-01/708 дугаар албан бичиг, Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газар, "Цахимд зөв байя" гуравдугаар шатны сургалтыг Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв Улсын төсөвт үйлдвэрийн газар, Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн Засаг даргын Тамгын газар, Сүхбаатар дүүргийн Ерөнхий боловсролын 13 сургууль, Чингэлтэй дүүргийн Ерөнхий боловсролын 13 сургуулийн 01/356 дугаар албан бичиг, Дэлхийн банк, "Олон нийтийн цахим мэдээллийн ажилтан бэлтгэх" туршилтын төслийн хүрээнд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн Сантай хамтран Дархан-Уул, Орхон, Хэнтий, Дорнод аймгийн боловсролын газар, Боловсролын яам, 'Мэдээлэл технологийн үндэсний парк" Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар зэрэг нийт 54 байгууллагатай хамтран ажиллаж байна. | |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 3: УЛСЫН ХЭМЖЭЭНД ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХҮРГЭХ, ХҮРТЭЭМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ, ТӨРӨЛЖҮҮЛЭХ, ОРОН НУТАГТ САЛБАРЫН БОДЛОГЫН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ** | | | | | | | |
| **Зорилт 3.1. Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэг байгуулах, зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангах, орон нутагт салбарын бодлогын холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх** | | | | | | | |
| 72. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэг байгуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн судалгааг боловсруулах | - | Судалгааны тоо | 1 | 1 | • Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэг байгуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн судалгааг 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдөр шинэчлэн боловсруулсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • "Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэг нээхэд тавигдах шаардлага"-ыг 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр боловсруулсан.<br>• Тус газрын 2024 оны А/02, А/31 дугаартай цэг байгуулах, А/11, А/17, А/37 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгт шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн судалгааг боловсруулж ажилласан. | |
| 73. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийг шинээр байгуулах, үйл ажиллагааг жигдрүүлэх | Улсын төсөв | Цэгийн тоо | 144 | 116 | Нийслэлийн хэмжээнд 68, хилийн чанад дахь 27 Дипломат төлөөлөгчийн газар, орон нутгийн хэмжээнд 201, нийт 296 "ХУРДАН" цэгийг шинээр байгуулж тохижуулан өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг жигдрүүлсэн. | 100 |
| 74. | Төрийн цахим үйлчилгээг бусдаар гүйцэтгүүлэх ажлыг зохион байгуулах | - | Байгууллагын тоо | 2 | 8 | Налайх, Багануур, Чингэлтэй, Хан-Уул, Багахангай дүүргийн Засаг даргын тамгын газар, Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс, "Дарь-Эх" нэгдсэн эмнэлэг, Сэлэнгэ аймгийн Мандал суман дахь Цахилгаан холбоо ХК-д төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийг байгуулж нийслэл, орон нутгийн хэмжээнд төр, хувийн хэвшлийн нийт 8 байгууллагаар төрийн үйлчилгээг гүйцэтгүүлсэн. | 100 |
| 75. | Төрийн цахим үйлчилгээний үйл ажиллагааг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх, боловсронгуй болгох судалгаа хийх | - | Судалгааны тоо | 4 | 1 | • Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/242 дугаар тушаалаар Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлтийн бодлого"-ын төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулах зорилтын хүрээнд Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яамдын цахим шилжилтийн бэлэн байдалд үнэлгээ хийх журмын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллан гадаад улсад байгаа Монгол Улсын иргэд төрийн үйлчилгээг авахад тулгарах хүндрэл, бэрхшээлийг тодорхойлох судалгааг нийт 33 Дипломат төлөөлөгчийн газраас 2024 оны 02 дугаар сард авч, судалгааны дүгнэлтийг боловсруулсан;<br>• Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /оператор/-ээр үйлчилгээ үзүүлэх ажлыг хавсран гүйцэтгэж байгаа 21 аймгийн 330 сумын албан хаагчдын судалгааг 2024 оны 03 дугаар сард авч нэгтгэсэн;<br>• Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон Аймгийн Засаг даргын хооронд 2024 онд хамтран ажиллах гэрээний 2.1.1.9 дэх заалтын хүрээнд тус газрын 05 дугаар сарын 17-ны өдрийн киоск машин байршуулах тухай 01/164 дугаар албан бичгийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 21 аймгийн Засаг даргын тамгын газарт хүргүүлж, эрэлт нийлүүлэлтийн судалгааг боловсруулж, дүгнэлтэд үндэслэн 88 "ХУРДАН" киоск машиныг байршуулсан. | |
| 76. | Төрийн цахим үйлчилгээний хөдөлгөөнт ХУРДАН цэг байгуулах, үйл ажиллагааг жигдрүүлэх | Улсын төсөв | Цэгийн тоо | 1 | 9 | Тус газрын 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/02 дугаар тушаалаар Төрийн цахим үйлчилгээний хөдөлгөөнт ХУРДАН цэг байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж Баянхонгор аймагт 1, Хэнтий аймагт 1, Дархан-Уул аймагт 1, нийслэлийн хэмжээнд 1 хөдөлгөөнт ХУРДАН цэгийг байгуулсан. Төрийн цахим үйлчилгээний хөдөлгөөнт ХУРДАН цэгээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд нийт 804 үйлчилгээ үзүүлсэн.<br>Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн төслийн хүрээнд хамтран хөдөлгөөнт ХУРДАН цэгийн тоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна.<br>Мөн Өмнөговь, Хөвсгөл, Дорнод, Говь-Алтай, Дундговь аймгийн Засаг даргын 2025 оны төлөвлөгөөнд Хөдөлгөөнт цэгийн төсвийг тусгуулсан. | 100 |
| 77. | Өөртөө үйлчлэх төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэг байгуулах, үйл ажиллагааг жигдрүүлэх | Улсын төсөв | Цэгийн тоо | - | 2 | Өвөрхангай аймгийн Арвайхээр сумын 5-р багийн цахим төвд, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын ЗДТГ-ын өргөтгөлийн байранд, Дархан-Уул аймгийн Дархан Өртөө-1 вагон вокзал дээр, Орхон аймгийн нутгийн удирдлагын ордны өргөтгөлд өөртөө үйлчлэх Төрийн цахим үйлчилгээний нийт 4 "ХУРДАН" цэг байгуулж хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллаж байна. | 100 |
| 78. | Төрийн цахим үйлчилгээтэй холбоотой хүн, хуулийн этгээдийн сэтгэл ханамжийн судалгаа хийх, үйлчилгээний чанар, сэтгэл ханамжийг дээшлүүлэх | Улсын төсөв | Судалгааны үр дүнгийн дундаж үзүүлэлтийн хувь | 86 | 95 | Нийслэл, орон нутгийн 1,890 иргэнээс сэтгэл ханамжийн судалгааг авсан. Судалгаанд оролцсон иргэдийн 74.6 хувь нь цаг хугацааг хэмнэж байна, 13.4 хувь нь эдийн засаг хэмнэж байна, бусад 12 хувь нь хүнд суртал буурсан гэсэн хариултыг өгсөн бөгөөд төрийн цахим үйлчилгээтэй холбоотой хүн, хуулийн этгээдийн сэтгэл ханамжийн судалгааны үр дүн 96%-ийн үзүүлэлттэй гарсан. | 100 |
| 79. | Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд 2024 онд хамтран ажиллах гэрээний холбогдох заалтын хэрэгжилтийг хангах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх | Улсын төсөв | Хэрэгжилтийн хувь | - | 70 | Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Аймгийн Засаг даргатай байгуулсан 2024 онд хамтрах ажиллах гэрээний зарим чиг үүргийн хэрэгжилтийн чиглэлээр зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэх ажлын удирдамжийг 2024 оны 09 дүгээр сарын өдөр 08-ны өдөр батлан 21 аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтсээр дамжуулан гэрээний хэрэгжилтийг дүгнэн зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан. Дорноговь, Орхон аймаг 90%, Архангай, Баянхонгор, Дархан, Өмнөговь аймаг 80%, Хэнтий, Өвөрхангай, Дундговь аймаг 70%, Хөвсгөл, Сэлэнгэ, Булган, Баян-Өлгий, Говь-Алтай аймаг 60%, Сүхбаатар, Говьсүмбэр аймаг 50%, Төв аймаг 23%-ийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэрэгжилттэй байгаа бөгөөд Увс, Ховд, Завхан, Дорнод зэрэг 4 аймгийн ирүүлсэн тайлан нь үнэлгээ өгөх боломжгүй байна. | |
| 80. | Орон нутагт харилцаа холбоо, мэдээллийн технологи, цахим засаглал, нийтийн мэдээллийн дэд бүтэц, кибер аюулгүй байдал, цахим орчинд хүний хувийн мэдээлэл хамгаалах, салбарын хүний нөөцийн хөгжил, салбарын мэргэжлийн хяналтын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх | Улсын төсөв | Хэрэгжилтийн хувь | - | 100 | • Тус газрын 21 аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтсийн дарга нарыг 2024 оны 01 дүгээр сард салбарын хууль тогтоомж, бодлогын хэрэгжилт, Аймгийн цахим шилжилтийн тайлан-2023, тус газрын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Кибер аюулгүй байдал сэдэвт сургалтад хамруулсан;<br>• Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Цахим хөгжил харилцаа холбооны яамнаас санаачлан 2 дугаар улиралд зохион байгуулсан “Цахимд хэвшье” арга хэмжээний ерөнхий зохион байгуулагчаар ажиллаж улсын хэмжээнд харилцаа холбоо мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төр, хувийн хэвшлийн байгууллагуудад салбарын талаар мэдээлэл өгч, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр ханган хамтран ажилласан;<br>• Кибер аюулгүй байдлын “Цахимд зөв байя” сургалтад орон нутгийн хэмжээнд 915 байгууллагын 23,879 албан хаагчийг хамруулсан. | 100 |
| **Зорилт 3.2. Төрийн цахим үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, хүртээмжийг сайжруулах** | | | | | | | |
| 81. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор) ашиглан хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний тоог нэмэгдүүлэх | Улсын төсөв | Үйлчилгээний тоо | 356,333 | 708,866 | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ээр дамжуулан нийслэлд 295,579, орон нутагт 651,557, хилийн чанадад 8,807, Монгол шуудан ХК-аар дамжуулан 24,061, Монголын цахилгаан холбоо ХК-аар дамжуулан 20,615, нийт 1,000,619 хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг хүргэж ажилласан. | 100 |
| 82. | Төрийн үйлчилгээний нэгдсэн лавлах төв байгуулах | Улсын төсөв | Төвийн тоо | 0 | 1 | • Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/187 дугаар тушаалаар Төрийн үйлчилгээний талаар хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангахад тулгамдаж буй асуудлыг судалж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн удирдамжийн дагуу “Төрийн үйлчилгээний талаар хүн, хуулийн этгээдэд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангахад тулгамдаж буй асуудал”-ыг тодорхойлохоор Нийслэл, орон нутгийн төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгээс үйлчилгээ авч буй 1,074 иргэнээс авсан судалгааны үр дүнд Төрийн үйлчилгээний нэгдсэн лавлах төв байгуулах шаардлагатай тухай дүгнэлт гарсан. Тус төвийг байгуулах ажлыг бүсдаар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Тус газрын өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах 7012-2626 тусгай дугаарт байршил, цагийн хуваарьтай холбоотой 273, гомдол, хүсэлт 64, талархал 194, заавар, зөвлөгөө, мэдээлэл 173, бусад асуудлаар хандсан 191, нийт 895 хүн, хуулийн этгээдийн дуудлагыг авч шийдвэрлэсэн. | |
| 83. | Төрийн үйлчилгээний /ТҮЦ/ машины ашиглалт үйлчилгээг хариуцах | - | ТҮЦ машины тоо | - | 40 | • Нийслэл, орон нутгийн хэмжээнд 104 ТҮЦ машины ашиглалт үйлчилгээ, хэвийн үйл ажиллагааг тус газрын албан хаагчид хариуцан ажилласан.<br>• Хүн амын тоо, зорчих хөдөлгөөний нягтрал, төрийн үйлчилгээний төвлөрөл, ачаалал, тасралтгүй ажиллах сүлжээ болон цахилгааны эх үүсвэр зэрэг шалгуур үзүүлэлтийг харгалзан улсын хэмжээнд нийслэлийн 6 дүүргийн 149, 18 аймгийн 110 байршилд киоск төхөөрөмж байршуулах шаардлагатай гэсэн судалгааны дүгнэлт гарсан. Тус дүгнэлтийн дагуу 2024 онд 84 ТҮЦ машиныг ашиглалт үйлчилгээнээс татан авч нийслэлийн 9 дүүргийн 125, орон нутгийн 126, нийт 251 байршилд киоск машиныг шинээр байршуулсан. Нийт: 267 ТҮЦ, Киоск машин | 100 |
| **СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛТ 4: ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРАМ, СТАНДАРТАД НИЙЦҮҮЛЭН ХҮРГЭЖ БАЙГАА ЭСЭХЭД ХЯНАЛТ ТАВИХ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | | | | | | | |
| **Зорилт 4.1. Холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх, хэвшүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих** | | | | | | | |
| 84. | Үйлчилгээний ажилтны үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт бусад шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох байгууллагад тайлан хүргүүлэх | - | Тайлангийн тоо | - | 1 | • Тус газрын 2023 онд хийсэн хяналт, шалгалтын ажлын нэгдсэн тайланг 2024 оны 01/25 дугаар албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн.<br>• 2024 оны эхний хагас жилд Хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газар, консуль, Монгол шуудан ХК-ийн салбараар үзүүлж байгаа ХУРДАН цэг, нийслэл, орон нутгийн 98 үйлчилгээний ажилтны үйл ажиллагаанд мөрдөгдөх хууль тогтоомж, дүрэм, журам, MNS:6984:2022 стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийсэн. Хяналт, шалгалтын тайлан, зөвлөмжийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, Стандарт хэмжилзүйн газарт тус тус албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 85. | Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих, зөвлөмж хүргүүлэх | - | Хяналт шалгалтын тоо, зөвлөмжийн тоо | 25<br>18 | 45<br>20 | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай, Цахим гарын үсгийн тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Тагнуулын ерөнхий газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу нийслэл дэх 12, аймаг дахь 33, хилийн чанад дахь 42, нийт 87 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ХУРДАН цэгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, 26 цэгт зөвлөмжийг боловсруулж үйл ажиллагаag сайжруулсан. | |
| **Зорилт 4.2. Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах, үр ашгийг шинжлэх** | | | | | | | |
| 86. | Үйлчилгээний цэгийн байршлын хүртээмжийг сайжруулах талаар судалгаа хийх, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллагад хүргүүлэх | - | Дүгнэлт, зөвлөмжийн тоо | 2 | 6 | Эм Ай Си Жи ХХК-аар гүйцэтгүүлсэн судалгааны дүгнэлтийг үндэслэн ХУРДАН цэгийн байршлын хүртээмжийг сайжруулахаар нийслэлийн 12 ХУРДАН цэгийн хэвийн үйл ажиллагаанд нийт 4 удаа хяналт шалгалт хийж, 5 цэгийн байршлыг өөрчлөх, 6 цэгийг татан буулгах, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх 4 дүгнэлт, зөвлөмж боловсруулж хэрэгжилтийг хангаж ажилласан. | 100 |
| 87. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, киоск)-ээр төрийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд хүргэснээр нийгэм эдийн засагт үзүүлэх үр ашгийн шинжилгээ хийх | - | Арга хэмжээний тоо | - | 1 | • Байгууллагын хүний нөөцийг чадавхжуулах зорилгоор олон улсын туршлага судалсны үндсэн дээр, олон улсын жишигт нийцсэн судалгааны асуулга боловсруулж судалгааны ажлыг зохион байгуулсан. Судалгааны үр дүнд үндэслэн 2025 онд "Төрийн цахим үйлчилгээтэй холбоотой хүн, хуулийн этгээдийн сэтгэл ханамжийн судалгаа", "Цахим шилжилтийн бэлэн байдлын талаарх судалгаа" "Бүх нийтийн цахим ур чадварын өнөөгийн нөхцөл байдлын судалгаа", "Нийтийн мэдээлэл хариуцагч байгууллагад ашиглаж байгаа системийн судалгаа" хийхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах тухай 01/430 дугаартай албан бичгийг Үндэсний статистикийн хороонд хүргүүлсэн.<br>• Хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний чиглэлийг тодорхойлох, нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх, судалгааны загвар гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж тус байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээний талаарх холбогдох судалгааг хийж ирүүлэх тухай 01/297 дугаар албан бичгийг Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлсэн. | 100 |
| **Зорилт 4.3. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, киоск)-ийн үйл ажиллагаанд хяналт тавих** | | | | | | | |
| 88. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, киоск)-ийн алдаа, доголдлыг илрүүлэх, дүн шинжилгээ хийх, холбогдох байгууллагад мэдэгдэл хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах | - | Мэдэгдлийн тоо | - | 12 | • Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ээр 2024 онд хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх явцад системтэй холбоотой гарсан 560 алдааг түүвэрлэж, нэгтгэлийг гарган 7 хоног бүр асуудал хариуцсан системс хөгжүүлэгч байгууллагад хүргүүлж, алдааг арилгуулсан. "И Монгол академи" улсын төсөвт үйлдвэрийн газарт 12 удаа мэдэгдэн, түүвэрлэсэн алдааны нэгтгэлийг албажуулан хүргүүлсэн.<br>• "И-Монгол академи" Улсын төсөвт үйлдвэрийн газарт тус газрын 2024 оны 01/06, 04/433 дугаар албан бичгээр хуулийн хэрэгжилтийг хангах тухай мэдэгдэл хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /оператор/-ээр үзүүлэх үйлчилгээг "Гэрэгэ киоск" ХХК киоск машинд нэвтрүүлэх ажлын хүрээнд цахим хэлбэрт шилжүүлэх 103 үйлчилгээг гэрээний дагуу нэвтрүүлсэн байдалд 2 удаа хяналт, шалгалтыг хийхэд киоск машинд 86 үйлчилгээ идэвхтэй, 19 үйлчилгээ идэвхгүй, мөн хууль, тогтоол, журмын өөрчлөлтийн дагуу хасах шаардлагатай 2 үйлчилгээ байна. Түүврийн аргаар үйлчилгээнүүдийг туршиж үзэхэд лавлагаа, тодорхойлолт хэсэгт хэрэглэгчийн дугаар, нэгж талбарын дугаар шаардаж цааш үйлчилгээ авах боломжгүй болдог. Үйлчлүүлэгч киоск машинаас үйлчилгээ авч дуусаад үргэлжлүүлэн дараагийн үйлчлүүлэгч үйлчилгээ авахад өмнөх хүний мэдээлэл хэвээр (дэлгэцэнд хадгалагдаж үлддэг) хадгалагддаг алдаа, доголдлууд илэрсэн.<br>• Ажлын хэсгээс Үндэсний дата төв Улсын төсөвт үйлдвэрийн газар, Гэрэгэ киоск ХХК -тай хамтарсан уулзалтыг 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулж, киоск машинд үйлчилгээний нэршил давхардсан, бичвэрийн алдаатай, мэдээллийн зөрүүтэй, төрийн байгууллагын нэр хуучнаар тусгагдсан зэрэг алдаа, доголдлыг засварлаж, киоск машины хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллах талаар үүрэг чиглэл өгсөн.<br>• Төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлэх киоск машины үйлчилгээнд Е болон Ц ангилал, Нийслэлийн гудамж замын хөдөлгөөнд ачааны авто машиныг цагийн хязгаарлалттайгаар оролцуулах түр зөвшөөрлийн системийн эх код авах тухай Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газарт цахим шуудан илгээж, "Үндэсний дата төв" Улсын төсөвт үйлдвэрийн газарт "Төрийн цахим үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх /киоск/" тендерт шалгарсан аж ахуйн нэгжүүдийн киоск машины үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан ажлын товч тайлан, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 03/1105 дугаар албан бичгийн дагуу мэдээлэл хүргүүлсэн тухай дүгнэлтийг "Үндэсний дата төв" Улсын төсөвт үйлдвэрийн газарт 2 удаа хүргүүлсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 03/1105 дугаар албан бичгийн дагуу хэрэгжүүлсэн ажлын мэдээллийг 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 01/371 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 89. | Үйлчилгээний ажилтны үйлчилгээ үзүүлэх ур чадварт хяналт тавих | - | Үйлчилгээний ажилтны тоо | - | 106 | Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ээр дамжуулан төрийн цахим үйлчилгээг үзүүлж байгаа 450 (*давхардсан тоогоор*) үйлчилгээний ажилтны харилцаа хандлага, харагдах байдал, эмх цэгцийг үнэлэх шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт, шалгалт хийж, үйлчилгээний ажилтнууд тоон гарын үсгээр үйлчилгээ үзүүлж чадахгүй, төлбөр тооцооны төхөөрөмж ажиллуулж чадахгүй, тоног, төхөөрөмжтэй ажиллах ур чадвар хангалтгүй байсан зэрэг илэрсэн зөрчлийг арилгуулахаар холбогдох байгууллага, нэгжид 5 удаа зөвлөмж хүргүүлж, 4 зөрчлийг арилгасан эсэхэд гүйцэтгэлийн хяналт, шалгалт хийж ажилласан. | 100 |
| **Зорилт 4.4. Үйлчилгээний ажилтны шалгуур үзүүлэлтийг тогтоох, үйл ажиллагаанд нь хяналт тавих** | | | | | | | |
| 90. | Ажлын байранд тавигдах шаардлага, үйлчилгээний ажилтны хандлага, харилцаа, үйлчилгээ үзүүлэх ур чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж батлах | - | Баримт бичгийн тоо | 1 | 3 | Тус газрын А/28 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн цахим үйлчилгээний ХУРДАН цэгийн үйл ажиллагааны түр журам"-д дараах өөрчлөлтийг оруулан шинэчлэн баталсан. Үүнд:<br>• ажлын байранд тавигдах тохижилт, тоног төхөөрөмж, нэмэлт хэрэгсэл, үйлчилгээний ажилтны хувцасны стандартад тавигдах 4 бүлгийн 49 шаардлага;<br>• цэгийн эмх цэгц, хэвийн үйл ажиллагааг үнэлэх үйлчилгээний цэгийн үзэмж, тохижилт, үйлчилгээний салбарын цэвэрлэгээ, мэдээллийн самбар зэрэг 3 бүлгийн 10 үзүүлэлт;<br>• үйлчилгээний ажилтны харилцаа, хандлага, үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харагдах байдал, эмх цэгцийг үнэлэх харилцах ур чадвар, хандлага үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харагдах байдал, эмх цэгцийг үнэлэх 4 бүлгийн 11 үзүүлэлт, нийт 70 шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, баталсан. | 100 |
| 91. | Мэдээллийн технологийн аудит хийх хуулийн этгээдтэй хамтран ажиллаж, зөвлөмж, дүгнэлтийн хэрэгжилтийг хангах | - | Тайлангийн тоо | - | 1 | • "ХУРДАН" цэгийн сүлжээний болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Тагнуулын ерөнхий газарт кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийлгэх хүсэлт гаргасан. Тус байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийн дагуу сүлжээний аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах ажлыг хэрэгжүүлсэн.<br>• Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Тагнуулын ерөнхий газрын даргын хамтарсан 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн А/30, А/148 дугаар тушаалаар батлагдсан "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлал"-ын дагуу аудит хийх байгууллагатай хамтран ажилласан.<br>• Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO:27001, Чанарын удирдлагын тогтолцоо ISO:9001 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд тус газрын 9 албан хаагч дотоод аудитор бэлтгэх сургалтад хамрагдсан.<br>• Тус газрын 2024 оны А/98 дугаар тушаалаар байгууллагын үйл ажиллагаа, хүн, хуулийн этгээдэд төрийн цахим үйлчилгээг операторын горимоор хүргэх ХУРДАН цэгт мэдээллийн аюулгүй байдлын аудит, кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн хуулийн этгээдээр хийлгэхээр холбогдох байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан. | |
| 92. | Олон улсын стандарт нэвтрүүлэхтэй холбогдуулан дагаж мөрдөх дүрэм, журмыг боловсруулж батлах, хэрэгжилтийг хангах | - | Дүрэм, журмын тоо | - | 4 | Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO:27001, Чанарын удирдлагын тогтолцоо ISO:9001 стандартыг нэвтрүүлэх ажлын хүрээнд тус газрын 9 албан хаагч дотоод аудитор бэлтгэх сургалтад хамруулж 4 журмын төслийг боловсруулсан. | 90 |
| **Зорилт 4.5. Төрийн үйлчилгээний процессыг оновчлох, дахин загварчлах, үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, хяналт тавих** | | | | | | | |
| 93. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолд нэмэлт өөрчлөлтийн оруулах санал боловсруулах, хүргүүлэх | - | Хүргүүлсэн саналын тоо | - | 1 | • Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-д 2024 оны эхний хагас жилийн байдлаар мэдээлэл хариуцагч 43 байгууллагын идэвхтэй 478 үйлчилгээ, идэвхгүй 75 үйлчилгээ байна. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад тусгагдсан 785 үйлчилгээнээс цахим хэлбэрт шилжүүлэхээр судлагдаж байгаа 24 байгууллагын 210 үйлчилгээ байна. Мөн тус тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан жагсаалтад нэмэлтээр Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор, И-бизнес, И-Монгол портал)-д байгаа 1086 үйлчилгээнээс мэдээлэл хариуцагч 20 байгууллагын 133 үйлчилгээ, мэдээлэл хариуцагч байгууллагаас шинээр цахим хэлбэрт шилжүүлэхээр хүсэлт ирүүлсэн 9 байгууллагын 31 үйлчилгээ, нийт 25 байгууллагын 164 үйлчилгээг нэвтрүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлтэд үндэслэн санал боловсруулж 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01/153 дугаар албан бичгээр Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хүргүүлсэн. | 100 |
| 94. | Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр мэдээлэл | Улсын төсөв | Байгууллагын тоо | 26 | 40 | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хүн, хуулийн этгээдэд үзүүлэх үйлчилгээний жагсаалт”-д орсон үйлчилгээнээс 58 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх боломжгүй гэсэн санал | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хариуцагч байгууллагатай хамтран ажиллах | | | | | ирүүлсэн 15 байгууллага, Цахим хөгжил, харилцаа холбоо яамнаас мэдээлэл хариуцагч байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр 8 албан бичиг ирүүлсний дагуу 17 байгууллага, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн систем (оператор)-ийн хэвийн үйл ажиллагааг хангах, үйлчилгээний шалтгаан нөхцөлийг тодруулах зорилгоор 21 байгууллага, нийт 56 байгууллагатай хамтран ажилласан. | |
| 95. | Төрийн үйлчилгээний процессыг оновчлох, дахин загварчлах, цахимжуулах ажлын хүрээнд холбогдох байгууллагатай хамтран ажиллах | - | Байгууллагын тоо | 10 | 11 | • "Шинэ сэргэлтийн бодлого"-ын төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, хүнд суртлыг бууруулах зорилтын хүрээнд тус газар нь Жижиг, дунд үйлдвэрийн газар, Шинэ сэргэлтийн бодлогын Хурдасгуур төв улсын төсөвт үйлдвэрийн газар, "Сис арт" ХХК-тай хамтран Жижиг, дунд үйлдвэрийн газрын хүн, хуулийн этгээдэд үзүүлж буй төрийн үйлчилгээнд процессын дахин загварчлал хийж үйл ажиллагааг нь оновчлох, лавлагаа, тодорхойлолт, олон шатлалт үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг 2024 оны А/34 дүгээр тушаалаар байгуулсан. Жижиг, дунд үйлдвэрийн газрын төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт, үйл ажиллагаанд дагаж мөрддөг дүрэм, журам, стратеги төлөвлөгөөний процессын зураглалыг хийж, бизнес процессын өнөөгийн нөхцөл байдлын тайлан, цаашдын үйл ажиллагаанд баримтлах загварыг шинэчлэн боловсруулсан.<br>• "Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "И-Монгол академи" улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран орон нутгийн төрийн байгууллагын төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтэрсэн үйлчилгээнд процессын шинжилгээ хийх, дахин загварчлах, шинээр цахим хэлбэрт шилжүүлэх үйлчилгээний судалгааг гаргах ажлын хэсэг нь дараах арга хэмжээг авч ажилласан.<br>✓ Орон нутаг дахь төрийн захиргааны 25 агентлагийн цахим хэлбэрт шилжүүлсэн үйлчилгээний нөхцөл байдлын шинжилгээ;<br>✓ Ашиглаж буй системүүдийн судалгаа;<br>✓ Цахим үйлчилгээ, сэтгэл ханамжийн судалгаа;<br>✓ Ахмадуудад зориулсан сургалт;<br>✓ Байгууллагуудын олон шатлалт үйлчилгээний сайжруулалт хийх арга хэмжээ;<br>✓ Хуучин үйлчилгээний системд өөрчлөлт хийх; | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ✓ Шинээр нэвтрэх үйлчилгээний бодлогын даалгавар боловсруулах;<br>✓ Сумдын үйлчилгээний ажилтнуудад сургалт зохион байгуулах;<br>✓ ERP/DOCX сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг зохион байгуулж ажилласан.<br>• Стандарт, хэмжил зүйн газраас хүн, хуулийн этгээдэд үзүүлдэг 6600 орчим И стандартыг төрийн үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж салбар дундын зохицуулалтыг хангаж ажилласан.<br>• Стандарт, хэмжил зүйн газрын үзүүлж байгаа үйлчилгээнд процессын дахин загварчлал хийж үйл ажиллагааг нь оновчлох, лавлагаа, тодорхойлолт, олон шатлалт үйлчилгээг төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд нэвтрүүлэхээр шийдвэрлэсэн. | |
| 96. | Үйлчилгээний ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх санал боловсруулах | - | Хяналтын тоо | - | 4 | • Үйлчилгээний ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх санал боловсруулах ажлын хүрээнд судалгааны MICG байгууллагатай хамтран нийслэл, орон нутгийн үйлчилгээний ажилтнуудын ажлын ачаалал, үйлчлүүлэгчийн ашиглалтын зорилго, үзүүлсэн үйлчилгээ, салбарын ачаалал, хугацаа, байршил зэрэг 6 үзүүлэлтээр судалгаа хийсэн.<br>• Нийслэлийн хэмжээнд Чингэлтэй дүүргийн Засаг даргын тамгын газар байрлах Хурдан цэг 11%, Төв шууданд байрлах Хурдан цэг 30%, нийт 41% буюу хамгийн их ачааллтай байна.<br>• Жилийн 52 долоо хоногоор авч үзэхэд хугацааны хувьд 3 дугаар сар харьцангуй ачаалал багатай байдаг бол 10 дугаар сард үйлчилгээний ачаалал хамгийн их байна.<br>• Судалгааны үр дүнгээс харахад нийслэлийн үйлчилгээний ажилтнуудын ажлын ачаалал их байдаг хэдий ч цэгийн байршлаас шалтгаалан харилцан адилгүй байна. Орон нутгийн хувьд авч үзэхэд жилийн зарим сард үйлчлүүлэгчгүй, зарим сард үйлчлүүлэгч тасралтгүй ирэх зэргээр ачаалал харилцан адилгүй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байгаа нь үйлчилгээний ажилтны ажлын ачааллыг тэнцвэржүүлэх зайлшгүй шаардлага байгааг харуулж байна. | 100 |
| 97. | Төрийн байгууллагаас нэвтрүүлсэн системд мэдээлэл байршуулах, хяналт тавих | - | Байгууллагын тоо | - | 92 | • Монгол Улсын Засгийн газрын "2023-2024 оныг авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" 49 дүгээр тогтоолын дагуу Засгийн газраас хэрэгжүүлж байгаа "Шил" ажиллагааны хүрээнд Аймгийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | /huduu.gov.mn, shilen.gov.mn/ | | | | | цахим хуудаст нийтэд ил тод байхаар заасан мэдээллүүдийг нээлттэй болгон Shilen.gov.mn-д байршуулах ажлыг аймаг дахь Төрийн цахим үйлчилгээний хэлтэстэй хамтран зохион байгуулж, мэдээлэл дутуу 56-75 оноотой 12 аймгаас 9 аймгийг 82-100 оноотой болгож мэдээллийг гүйцээж shilen.gov.mn цахим хуудаст оруулсан.<br>• Монгол Улсын Засгийн газрын "Шил" ажиллагааны хүрээнд төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг даргын Тамгын газар, сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн харьяа газар, хэлтсийн нийт 1910 албан хаагчдыг хамруулан Нээлттэй мэдээллийн систем /shilen.gov.mn/-ийн 2.0 хувилбар дахь "Шилэн индекс"-ийн үнэлгээ, харьяа болон салбар байгууллагуудын хэмжээнд "Шилэн индекс"-ийн тайланг хүлээн авч, хянах, үнэлэх, баталгаажуулах нээлттэй мэдээллийн дата оруулах, шинэчлэх зэрэг сэдвүүдээр нээлттэй мэдээллийн систем "SHILEN.GOV.MN"-ийн 2.0 хувилбарын сургалтыг зохион байгуулсан.<br>• Нийтийн мэдээллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1. дэх хэсэгт заасан мэдээлэл хариуцагч байгууллагын байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг нээлттэй мэдээллийн "Shilen.gov.mn" системд байршуулсан мэдээлэл хариуцагч 224 байгууллагын нээлттэй мэдээллийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үнэлэн, хянан баталгаажуулж, хэвлэн нийтэлсэн.<br>• Нээлттэй мэдээллийн систем "SHILEN.GOV.MN"-д төрийн байгууллагуудын байршуулсан нээлттэй мэдээллийг үнэлэх, баталгаажуулж, хэвлэн нийтлэх асуудлаар Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/46 дугаар тушаалаар байгуулагдсан Авлигатай тэмцэх "5Ш" ажиллагааны хүрээнд "Шил ажиллагаа"-ны хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар ханган, шаардлагатай мэдээ, мэдээллийг нэгтгэж, шилэн индексийн үнэлгээг зарлах үүрэг бүхий Штаб, Аствишн ХХК-ийн удирдлага болон холбогдох албан хаагчидтай 2024 оны 05 дугаар сарын 31, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр уулзалт зохион байгуулж, системд гарч байгаа алдаа доголдлыг арилгах, сайжруулах арга хэмжээний талаар харилцан санал | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | солилцсон. Нийт 1910 албан хаагчдыг зөвлөгөө мэдээллээр хангаж ажилласан. | | |

**МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| 1. | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага” сэдэвт сургалтад хамрагдах | Сургалтын тоо | - | 1 | Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” сургалтын хөтөлбөрийн хүрээнд Төрийн албан хаагчдын санхүүгийн боловсролын түвшинг дээшлүүлэх, хуримтлалын ач холбогдлын талаар сурталчлан таниулах зорилготой “Байгууллага, хувь хүний санхүүгийн төлөвлөлт, удирдлага” сэдэвт сургалтад 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдөр хамрагдсан. | 03 | 100 |
| 2. | Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Дижитал шилжилт, Виртуал орчинд ажиллах” сэдэвт сургалтад хамрагдах | Сургалтын тоо | - | 1 | 2024 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” сургалтын хөтөлбөрийн хүрээнд Төрийн албан хаагчдын мэдээллийн технологийн мэдлэгт орчин үеийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж буй туршлага, ололт амжилт, цахим орчинд шилжиж ажиллах зорилготой “Дижитал шилжилт, Виртуал орчинд ажиллах” сэдэвт сургалтад хамрагдсан. | 03 | 100 |
| 3. | Мэдээллийн технологийн хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцох | Хэлэлцүүлгийн тоо | - | 1 | 2024 оны 05 дугаар сарын 14-ний зохион байгуулагдсан хөдөлмөрийн зах зээл дэх ажлын байрыг нэмэгдүүлэх, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл эрхлэгч нарт төрөөс үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэгийг тодорхойлох, Салбарын олон улсын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт татах боломжийг сайжруулах зорилго бүхий Мэдээллийн технологийн хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцож санал өгсөн. | 05 | 100 |
| 4. | “Төрийн албан хаагчийн хөгжил хамгаалал” хуулийн төслийн хэлэлцүүлэгт оролцох | Хэлэлцүүлгийн тоо | - | 1 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Удирдлагын академи, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хамтран 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн хөгжил хамгаалал” хэлэлцүүлэгт хамрагдсан. | 05 | 100 |
| 5. | “Бүсчилсэн хөгжил-Монголын эдийн засгийн | Арга хэмжээний тоо | - | 1 | Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг “Бүсчилсэн хөгжлийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан 2024 оны 02 дугаар сарын 01-03-ны өдөр | 02 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | форум” арга хэмжээнд оролцох | | | | зохион байгуулагдсан “Бүсчилсэн хөгжил-Монголын эдийн засгийн форум”-д хамрагдсан. | | |
| 6. | Сансар судлалын хүрээнд зохион байгуулсан сургалтад хамрагдах | Сургалтын тоо | - | 1 | Монгол улсын их сургуулийн багш дэд профессор Д.Эрдэнэбаатарын зохион байгуулсан “Аж үйлдвэрийн хувьсгалууд ба сансар судлал” сэдэвт сургалтад 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр хамрагдсан. | 04 | 100 |
| 7. | Олон улсын болон бүс нутгийн байгууллагаас тогтмол зохион байгуулдаг хурал, зөвлөгөөн, семинар, сургалтад хамрагдах | Сургалтын тоо | - | 1 | Испанийн Хаант Улсад 2024 оны 02 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Дэлхийн үүрэн холбооны конгресс 2024” арга хэмжээнд хамрагдаж олон улсын туршлага судалсан.<br>Бүгд Найрамдах Япон Улсын Токио хотод 07 дугаар сарын 22-26-ны хооронд зохион байгуулагдсан “Дэлхийн банк”, “Токиогийн сургалт хөгжлийн төв”-ийн хамтарсан “Кибер аюулгүй байдал” сэдэвт сургалтад хамрагдсан. | 02-07 | 100 |

*Төлөвлөгөөг хянасан:*
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд

***Төсвийн Ерөнхийлөн захирагч***
.......................... /Э.Батшугар/
.... .... ......

*Төлөвлөгөө тайлагнасан:*
Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дарга

***Төсвийн Шууд захирагч***
.......................... /П.Батбаатар/
.... .... ......